

ОГНОО: 2015 ОНЫ 04 ДУГААР САРЫН 01-НИЙ СДӨР

(1) ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР

болон

(2) БАГАНУУР ПАУЭР ХХК-ИЙН
хооронд байгуулсан

"БАГАНУУРЫН ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
(БАРИХ-АШИГЛАХ-ШИЛЖҮҮЛЭХ)

КОНЦЕССЫН ГЭРЭЭ

УЛААНБААТАР ХОТ
2015

ГЭРЭЭНИЙ АГУУЛГА


НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
- ХОЁР. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ, ГЭРЭЭГ ТАЙЛБАРЛАХ
 - 2.1. Нэр томъёог тайлбарлах
 - 2.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэх
- ГУРАВ. КОНЦЕССЫН ЗҮЙЛ, ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ
 - 3.1. Концессын зүйл
 - 3.2. Концессын төрөл
 - 3.3. Концессын гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл
 - 3.4. Концессын гэрээ хэрэгжих нөхцөл
 - 3.5. Концессын хугацаа
 - 3.6. Концессын гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөл
 - 3.7. Концессын гэрээг сунгах
 - 3.8. Концессын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах
 - 3.9. Концессын зүйлийг ашиглах концесс эзэмшигчийн онцгой эрх
 - 3.10. Концесс эзэмшигчид хориглох зүйл
 - 3.11. Концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих
 - 3.12. Санхүүгийн хаалтын баталгаа ба Гүйцэтгэлийн баталгаа
 - 3.13. Концессын төлбөр
- ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ
 - 4.1. Концесс олгогчийн эрх, үүрэг
 - 4.2. Концесс эзэмшигчийн эрх, үүрэг
- ТАВ. КОНЦЕСС ХЭРЭГЖИХТЭЙ ХОЛБООТОЙ БУСАД АСУУДАЛ
 - 5.1. Газаршиглуулах
 - 5.2. Нүүрсхангалт
 - 5.3. Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах ба үнэ тариф
 - 5.4. Даатгал
 - 5.5. Техникийн нөхцөл, үзүүлэлт
 - 5.6. Санхүү, хөрөнгө оруулалт
- ЗУРГАА. МЭДЭГДЭЛ БА БАТАЛГАА
- ДОЛОО. КОНЦЕССЫН ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ
 - 7.1. Концессын гэрээ дуусгавар болох
 - 7.2. Концессын гэрээг Концесс олгогчийн санаачилгаар цуцлах
 - 7.3. Концессын гэрээг Концесс эзэмшигчийн санаачилгаар цуцлах
 - 7.4. Давагдашгүй хүчин зүйл бий болсны улмаас гэрээ цуцлах
 - 7.5. Гэрээг түдгэлзүүлэх
 - 7.6. Гэрээ цуцлах урьдчилсан мэдэгдэл хүргүүлэх
 - 7.7. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал тохиролцоонд хүрээгүй тохиолдолд
 - 7.8. Концессын зүйлийг хүлээлгэн өгөх
 - 7.9. Концессын гэрээг цуцлах нөхөн олговрын хэмжээг тооцох
- НАЙМ. ХАРИУЦЛАГА
- ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ
- АРАВ. БУСАД ЗҮЙЛС
 - 10.1. Хууль хэрэглэх
 - 10.2. Хууль тогтоомж өөрчлөгдөх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээ
 - 10.3. Давагдашгүй хүчин зүйл
 - 10.4. Давагдашгүй хүчин зүйл арилсны үр дүнд авах арга хэмжээ
 - 10.5. Нууцлал



- 10.6. Сяуны өмч
- 10.7. Мэдэгдэл хүргүүлэх
- 10.8. Бусад зүйл

ХАВСРАЛТУУД

Handwritten signature and a rectangular stamp.

НИЙТЛЭГҮНДЭСЛЭЛ

Улсын Их Хурлын 2009 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн "Төр-хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай" 64 дүгээр тогтоол, Улсын Их Хурлаас 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр баталсан Концессын тухай хууль, Засгийн газрын 2013 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай" 317, Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 9-ний өдрийн "Концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай" 88 тоот тогтоолыг тус тус **ҮНДЭСЛЭН:**

НЭГ ТАЛААС

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 88 тоот тогтоолоор энэхүү гэрээг байгуулах эрхийг олгосноор түүнийг төлөөлж Хөрөнгө оруулалтын газар(цаашид "Эрх бүхий этгээд" эсвэл "Концесс олгогч" гэх)

НӨГӨӨ ТАЛААС

Багануур Пауэр ХХК (Цаашид "Концесс эзэмшигч" гэх) хооронд [2015 оны 04 дүгээр сарын 01]-ний өдөр энэхүү Концессын гэрээг байгуулав.


Гэрээг ийнхүү байгуулахдаа

- (А) Концесс олгогч нь уралдаант шалгаруулалтыг зарласан бөгөөд "Си Эн Ай 22 Констракшн ба Пинггао Групп Компани"-ийн нэгдлээс бүрдэх Консорциум (цаашид Консорциум гэх) нь оролцох хүсэлтээ ирүүлж шалгуур үзүүлэлтүүдийг хангаснаар оролцогчдын жагсаалтад орсон,
- (Б) Консорциум нь уралдаант шалгаруулалтын баримт бичгийн дагуу төслийн саналаа ирүүлсэн бөгөөд Концесс олгогчтүүнтэй концессын төслийн гэрээний нөхцөлийг хэлэлцсэний үндсэн дээр хамгийн сайн харилцан тохиролцсоноор уралдаант шалгаруулалтын ялагч болсон,
- (В) Эрх бүхий этгээдтэй тохиролцсоноор Консорциум нь Багануур Холдинг Лимитед компанийн бүрэн эзэмшилд Концесс эзэмшигч болох "Багануур Пауэр" ХХК хуулийн этгээдийг байгуулсан.
- (Г) Концесс эзэмшигч нь концессын гэрээг байгуулах, Багануурын цахилгаан станц, холбогдох байгууламж, дагалдах барилгыг (цаашид Төсөл гэх) санхүүжүүлэх, барих, ашиглах зорилгоор төслийн компани хэлбэрээр байгуулагдсан зэргийг үндэслэв.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээний зорилго нь концессыг хэрэгжүүлэхэд шаардлагатай 1.2-т дурьдагдсан Концесс олгогчболон зохицуулах байгууллагын эрх үүрэг, концесс эзэмшигчийн гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний нөхцөл, хамрах хүрээ, эдлэх онцгой эрхийн хэмжээ, төслийг санхүүжүүлэгчийн эрх үүрэг, концессын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах нөхцөл, хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх, дуусгавар болгох, түдгэлзүүлэх, цуцлах, төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, маргаан хянан шийдвэрлэхэд талуудын хүлээх эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Концессыг хэрэгжүүлэхэд дор дурдсан байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:



1.2.1. Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангуулах, концессын зүйлийг барьж байгуулах нөхцөлийг хангах, дэмжлэг үзүүлэх, цахилгаан станцын барилга, байгууламж барих тусгай зөвшөөрлийг олгож, угсралтын явцад хяналт тавьж, үйл ажиллагааг нь зохицуулах.

1.2.2. Эрчим хүчний зохицуулах хороо нь Эрчим хүчний тухай Монгол улсын хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 13 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн дагуу эрчим хүчний барилга байгууламж барьж байгуулах, цахилгаан үйлдвэрлэх, эрчим хүчээр хангах тусгай зөвшөөрлийг концесс эзэмшигчид олгож, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үнэ тарифыг хянаж батлах ажлыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх;

1.2.3. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Цахилгаан станцын барилгын ажлыг эхлүүлэх тусгай зөвшөөрлийг олгож, Барилгын тухай хууль тогтоомжийн дагуу барилгын ажлын нөхцөл шаардлагыг хангуулж, хяналт тавих;


1.2.4. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль"-ийн 4,5,6 дугаар зүйлүүдэд заасны дагуу төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ, байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг баталж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах, шаардлагатай тохиолдолд дээрх хуулийн 7,8 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ, хянан магадлагаа хийх;

1.2.5. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Соёлын өвийг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 27.8-д заасны дагуу газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгүүлж, дүгнэлт гаргуулах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах.

1.3. Дараах дагалдах бусад гэрээнүүд нь энэ Гэрээний салшгүй хэсэг байна. Үүнд:

1.3.1.	энэ Гэрээний хавсралт №4:	Нүүрс худалдах, худалдан авах гэрээ;
1.3.2.	энэ Гэрээний хавсралт №5:	Газар ашиглах гэрээ;
1.3.3.	энэ Гэрээний хавсралт №6:	Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ;
1.3.4.	Энэ Гэрээний хавсралт №7	Дулаан худалдах, худалдан авах гэрээ
1.3.5.	энэ Гэрээний хавсралт №8	Ус ашиглах гэрээ;
1.3.6.	энэ Гэрээний хавсралт №10:	Хяналтын гэрээ

1.4. Техник, эдийн засгийн үндэслэл (энэ Гэрээний хавсралт 1)-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг эрчим хүчний салбарын шинжлэх ухаан технологийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.



**ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ,
ГЭРЭЭГ ТАЙЛБАРЛАХ**

2.1. Нэр томьёог тайлбарлах

Энэхүү Гэрээнд дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:

2.1.1. **“Ажиллах хүч”** гэж Концессын зүйлийг барьж байгуулах, ашиглах явцад концесс эзэмшигч болон цахилгаан станцын ашиглалтыг хэрэгжүүлэгчтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан, ажил үүрэг гүйцэтгэж байгаа үндсэн болон гэрээт ажиллагсдыг;

2.1.2. **“Ашиглалтад оруулах хугацаа”** гэж цахилгаан станцын эхний блокын барилга байгууламжийг бүрэн барьж дуусгаж, хэвийн, найдвартай ажиллагааг жигдрүүлж, шалгаж, туршилт хийснээр Эрх бүхий комисс дүгнэлт гаргаж баталгаажуулах хугацааг; Ашиглалтад оруулснаар ашиглалтын хугацаа эхэлнэ.

2.1.3. **“Эрх бүхий комисс”** гэж цахилгаан станцын барилгын ажил дуусахад шалган, туршилт хийж, ашиглалтын үйл ажиллагааг баталгаажуулах үүрэг бүхий Эрчим хүчний сайдын 2013 оны 98-р тушаал, Засгийн газрын 2012 оны 151-р тогтоолын дагуу байгуулагдсан комиссыг;

2.1.4. **“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ”** гэж “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн 4-р зүйлд заасныг;

2.1.5. **“Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ”** гэж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу эрх бүхий байгууллагаас гаргасан (энэ Гэрээний хавсарт 2) нарийвчилсан үнэлгээг;

2.1.6. **“Барилга, байгууламж”** гэж “Барилгын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасныг;

2.1.7. **“Барилгын ажлын гэрээ”** гэж Концессын гэрээний урьдчилсан нөхцөлийн дагуу Концесс эзэмшигч болон Барилгын ажил гүйцэтгэгчийн хооронд магадлагдсан зураг төслийн дагуу Барилгын ажил гүйцэтгэх тухай байгуулсан гэрээг;

2.1.8. **“Барилгын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл”** гэж Барилгын тухай Монгол улсын хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу концесс эзэмшигчид олгох тусгай зөвшөөрлийг;

2.1.9. **“Барилгын ажлын үе шатны ажлын төлөвлөгөө”** гэж зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, ашиглалтад оруулах үйл ажиллагаа тус бүрд хийгдэх ажлын технологийн дараалал, хуваарийг (энэ Гэрээний хавсралт 3);

2.1.10. **“Барилгын ажлыг дуусгах”** гэж Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн дагуу бүртгэлийн дугаар олгосноор тухайн барилга байгууламжийг ашиглалтад орсныг тооцохыг хэлнэ. Маргаангүй байдлын үүднээс, эхний блок бүрэн хүчин чадлаараа тасралтгүй 72 цагийн туршилтын ажиллагаа дууссанаар барилгын ажил дууссанд тооцно;


2.1.11. **“Барилгын норм, нормативын баримт бичиг”** гэж барилга байгууламжид мөрдөх нийтлэг шаардлага зарчмыг агуулсан барилгын норм, дүрэм, стандарт, цомог, заавар, журмыг;

2.1.12. **“Барилгын техникийн нөхцөл”** гэж Барилгын тухай хуулийн 3.1.7-д заасныг;

2.1.13. **“Барих-ашиглах-шилжүүлэх концессын төрөл”** гэж Монгол улсын Концессын тухай хуулийн 4.1.1 дүгээр зүйлд тодорхойлсноор концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан хугацаанд ашиглан, гэрээний хугацаа дуусгавар болоход гэрээнд заасан нөхцөлөөр төрийн



- болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх энэ Гэрээний төрлийг;
- 2.1.14. "Бие даасан инженер" гэж Концесс олгогчболон Концесс эзэмшигч хамтран томилсон [техникийн/санхүүгийн эксперт/экспертүүд], эсхүл Эрх бүхий этгээд, Концесс эзэмшигч тухай бүрд томилж болох, Хяналтын гэрээнд үүргийг нь тусгасан зөвлөх инженер/инженерүүд, эксперт/экспертүүдийг;
- 2.1.15. "Хяналтын гэрээ" гэж Концесс олгогчоор хянагдаж, Концесс эзэмшигч, Бие даасан инженерийн хооронд байгуулсан ашиглалтанд орох хүртэлх барилгын ажлын үе шатны төлөвлөгөөнд хяналт тавих гэрээг (Хавсралт 10),
- 2.1.16. "Бүтээгдэхүүн нийлүүлэх цэг" гэдэгт цахилгааны нийлүүлэлтийн хэмжээг бүртгэх зориулалт бүхий тооцооны болон хяналтын тоолуур суурилагдсан холболтын шугамыг цахилгаан дамжуулах шугамтай холбож буй цэгийг;
- 2.1.17. "Бүтээгдэхүүн үйлдвэрлэж, арилжаалж эхлэх өдөр" гэдэгт цахилгаан үйлдвэрлэх 2 генераторын эхний генераторт туршилт тохируулга хийгдэж 72 цагийн турш бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж иж бүрэн ашиглалтад оруулан, эрх бүхий төрийн байгууллагаархүлээлгэн өгсөн өдрийгхэлнэ. Бүтээгдэхүүн үйлдвэрлэж, арилжаалж эхлэх өдөр нь барилгын ажлыг дуусгах өдөр байна ;
- 2.1.18. "Газар ашиглах гэрээ" гэж концесс эзэмшигч, орон нутгийн газрын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагын хооронд байгуулсан газар ашиглах нөхцөл журмыг тохиролцсон энэ Гэрээний 1.3.2-т дурьдсан гэрээг;
- 2.1.19. "Гүйцэтгэлийн баталгаа" гэж энэхүү Концессын гэрээний 3.12-т заасны дагуу шаардагдах гүйцэтгэлийн баталгааг;
- 2.1.20. "Гэрээ хүчин төгөлдөр болсон өдөр" гэж талуудын хууль ёсны төлөөлөгчид гарын үсэг зурж, тамгалснаар;
- 2.1.21. "Гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл" гэж энэ Гэрээний 3.3-т заасан нөхцөлийг;
- 2.1.22. "Давагдашгүй хүчин зүйл" гэж хохирогч талын санаатай, санамсаргүй үйлдэл, эс үйлдлээс шалтгаалаагүй, урьдчилан мэдээгүй буюу мэдэх боломжгүй байсан, энэ Гэрээний 10.3-т заасан нөхцөл байдал бий болсныг;
- 2.1.23. "Төсөл" гэж энэ Концессын гэрээнд заасан Багануурын цахилгаан станц, холбогдох байгууламж, мөн дагалдах барилгыг барьж, ашиглахыг,
- 2.1.24. "Холбогдохбайгууламж" гэж техник эдийн засгийн үндэслэл (энэ Гэрээний хавсралт 1)-ээр тодорхойлсон цахилгаан станцын эдэлбэр газар доторх зам, гүүр, ус суваг, цэвэр бохир усны систем, далан хаалт, түлш, нүүрс дамжуулах хэрэгслийн инженерийн шугам сүлжээ, болон бусад суурилагдсан байгууламжуудыг;
- 2.1.25. "Дагалдах барилга" гэж орон сууцны барилгууд, нэг сургууль, нэг цэцэрлэг, нэг тоглоомын талбай, ТЭЗҮ-д заагдсан цахилгаан станцын газраас гадна байрлах үйлчилгээний газруудыг хэлнэ. Сургууль болон цэцэрлэгийг концесс эзэмшигч барьж байгуулан, дуусгаснаар Концесс олгогчид шилжүүлэн өгөх бөгөөд Төслийн шаардлагыг хангах хүрээнд хязгаарлагдана. Концесс олгогч нь сургууль, цэцэрлэгийг эзэмших бөгөөд холбогдох хариуцлага, эрсдэлийг өөрөө хариуцна. Орон сууцны барилга, тоглоомын талбай, бусад үйлчилгээний газруудыг концесс эзэмшигч эзэмшинэ.
- 2.1.26. "Дагалдах бусад гэрээ" гэж энэ Гэрээний нэгдүгээр бүлгийн ерөнхий нөхцөлийн 1.3-т дурдсан гэрээг;
- 2.1.27. "Засвар, үйлчилгээний ажил" гэж концессын зүйлийг ашиглалтын



7 [Z]

явцад техникийн стандарт, норм, нормативын дагуу засварлах, засан сайжруулах, сэргээн засварлах, их засвар, үйлчилгээг;

2.1.28. "Зураг төсөл" гэж барилга байгууламжийг барих ТЭЗҮ, техникийн болон ажлын зураг, инженер-геологийн судалгааны дүгнэлт, геодезийн зураглал, барилга байгууламжийн өртгийн нэгдсэн төсвийг;

2.1.29. "Зохицуулах байгууллага" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу концессыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл олгох, үнэ тариф тогтоох, концессын зүйл, эсхүл түүгээр үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг батлах, мөрдүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагыг;

2.1.30. "кВт" гэдэгт киловаттыг;

2.1.31. "кВт.ц" гэдэгт киловатт цагийг;

2.1.32. "Концесс олгогч" гэж Монгол улсын Засгийн Газрыг төлөөлөх Монгол улсын Хөрөнгө оруулалтын агентлагийг;

2.1.33. "Концесс эзэмшигч" гэж концесс авсан "Багануур пауэр" ХХК-ийг, Концесс эзэмшигч нь зөвхөн төслийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан компани бөгөөд төслийн хугацаанд ямар нэгэн бусад бизнесийн үйл ажиллагаанд оролцохгүй болно;

2.1.34. "Концесс" гэж концесс олгогчоос Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу концесс эзэмшигчид олгож буй энэ Гэрээний 3.9-д заасан онцгой эрхийг;

2.1.35. "Концессын гэрээг байгуулсан өдөр" гэж энэ Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрийг;

2.1.36. "Концессын гэрээний хугацаа" гэж энэ Гэрээний 3.5.1-д заасан хугацааг;

2.1.37. "Концессын гэрээ хэрэгжиж эхлэх өдөр" гэж энэ Гэрээний 3.5.2-т заасан утгыг;

2.1.38. "Станцын барилгын ажил эхлэх өдөр" гэж 1) санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурсан ба 2) Төслийн барилгын ажлын зөвшөөрөл олгогдох өдрийн аль дараа нь биелсэн өдрийг хэлнэ. Станцын барилгын ажил эхлэх өдөр нь Концессын гэрээний хугацаа эхлэх өдөр байна.

2.1.39. "Концессын зүйл" гэж энэ Гэрээний 3.1.-т тодорхойлсныг;

2.1.40. "Концессын зүйлийг бүрэн шилжүүлж хүлээлгэн өгөх хугацаа" гэж энэ Гэрээний 7.8.2-т заасан өдрийг;

2.1.41. "Концессын зүйлийг хүлээлцэх комисс" гэж Гэрээний 7.8.1-т заасан үүрэг бүхий комиссыг;

2.1.42. "Концессын зүйлийг ашиглах" гэж энэ Гэрээнд заасан нөхцөлөөр концессын зүйлийг ашиглахыг;

2.1.43. "МВт" гэдэгт мегаваттыг;


2.1.44. "Нийлүүлсэн цахилгаан" гэж концесс эзэмшигчийн үйлдвэрлэж, бүтээгдэхүүн арилжаалах цэгт нийлүүлсэн, кВт.ц-аар илэрхийлэгдсэн цахилгааны хэмжээг;

2.1.45. "Нүүрс" гэж нүүрсний уурхайгаас олборлож, цахилгаан станцад эрчим хүчний эх үүсвэр болгож ашиглах эрчим хүчний нөөцийг;

2.1.46. "Нүүрс худалдах, худалдан авах гэрээ" гэж концесс эзэмшигч, нүүрсний уурхайхооронд байгуулсан нүүрсээр хангах нөхцөл журмыг тохиролцсон энэ Гэрээний 1.3.1-д дурдсан гэрээг;

2.1.47. "Татвар" гэж Монгол улсын Татварын тухай хуулийн хүрээнд концесс эзэмшигчийн төлөх бүхтөрлийн албан татвар, хураамж, төлбөрийг;

2.1.48. "Техник эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх)" гэж энэ Гэрээний хавсралт 1-ээр тодорхойлж, эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Шинжлэх ухаан технологийн



- зөвлөлийн хурлаар баталсан, цахилгаан станц барих, ашиглах, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх техникийн нөхцөл, эдийн засгийн тооцоо, төлөвлөлт, судалгааг агуулсан баримт бичгийг;
- 2.1.49. "Төслийн газар" гэж концесс эзэмшигч төслийг хэрэгжүүлэх зорилгоор газар [эзэмших ашиглах] гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу эзэмшиж ашиглаж буй газрыг;
- 2.1.50. "Үүсгэн байгуулагчийн шийдвэр" гэж Концесс эзэмшигч компанийг байгуулахаар хувь нийлүүлэгчдээс гаргасан шийдвэрийг (Хавсралт 11)
- 2.1.51. "Ус ашиглах гэрээ" гэж концесс эзэмшигч, орон нутгийн усны асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагын хооронд байгуулсан усны нөөц ашиглах нөхцөл журмыг тохиролцсон энэ Гэрээний 1.3.5-т дурдсан гэрээг;
- 2.1.52. "Усны нөөц" гэж энэ төсөлд ашиглах гадаргын болон газрын хөрсөн доорх болон саарал усыг;
- 2.1.53. "Үйлдвэрлэл явуулах хугацаа" гэж Төслийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, арилжаалж эхлэх өдрөөс Концессын гэрээний хугацаа дуусах хүртэлх концесс эзэмшигч цахилгаан станцыг ашиглан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хугацааг;
- 2.1.54. "Концесс эзэмшигчтэй холбогдох этгээд" гэж концесс эзэмшигчийн хувьцааны хяналтын багцыг эзэмшдэг болон тэдэнд хяналтын багцаа эзэмшүүлдэг иргэн, хуулийн этгээдийг;
- 2.1.55. "Санхүүжүүлэгчид" гэж концесс эзэмшигчтэй энэхүү гэрээнд заагдсан төслийн санхүүгийн дэмжлэгийг үзүүлэгч, санхүүжилтийн гэрээ байгуулсан санхүүгийн байгууллагыг;
- 2.1.56. "Хуанлийн жил" гэж жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааг;
- 2.1.57. "Хуанлийн улирал" гэж жилийн дараалсан 3 сар буюу (I) 1, 2, 3 дугаар сар, (II) 4, 5, 6 дугаар сар, (III) 7, 8, 9 дүгээр сар, (IV) 10, 11, 12 дугаар сарыг;
- 2.1.58. "Хуанлийн сар" гэдэгт хуанлийн 12 сарын аль ч сарыг;
- 2.1.59. "Хэмжих хэрэгсэл" гэж тооцооны болон хяналтын тоолуурыг хамтад;
- 2.1.60. "Хяналтын багц" гэж концесс эзэмшигчийн гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг;
- 2.1.61. "Цахилгаан" гэж цахилгаан станцын барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулах хугацаанд концесс эзэмшигчийн төвийн эрчим хүчний эх үүсвэрээс гэрээний дагуу авч ашиглах, үйлдвэрлэл явуулах хугацаанд станц өөрөө үйлдвэрлэж, нийлүүлэх цахилгаан эрчим хүчийг;
- 2.1.62. "Цахилгаан станц" гэж Техник, эдийн засгийн үндэслэлээр тодорхойлсон тус бүр нь 2х350МВт-ын хүчин чадал бүхий Багануур дүүрэгт Концессын гэрээний Барих-Ашиглах-Шилжүүлэх нөхцөлөөр баригдах, нүүрсээр ажиллах дулааны цахилгаан станцыг хэлнэ. Цахилгаан станц нь бүрдүүлэх хэсэг, цахилгаан дамжуулах шугам болон холбогдох байгууламжуудыг агуулах болно.
- 2.1.63. "Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ" гэж концесс эзэмшигч болон Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ компанийн хооронд байгуулсан цахилгаан эрчим хүч нийлүүлэх, худалдан авах нөхцөл журмыг тохиролцсон гэрээг;
- 2.1.64. "Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл" гэж Эрчим хүчний тухай Монгол улсын хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу эрчим хүчний барилга байгууламж барих зөвшөөрөл олгосныг;
- 2.1.65. "Хөрөнгө оруулалт" гэж цахилгаан станцын төслийг



хэрэгжүүлэхтэй холбогдуулан ТЭЗҮ-д тооцоолсон зардлууд, мөн консорциумын тендерт оролцох, сонгогдох, хэлэлцээр хийх, гэрээг зурахтай холбогдон гарсан зардлуудыг оруулан тооцно,

2.1.66 "Алдагдал" гэж цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарч болох доорх болон бусад алдагдлыг хэлнэ. 1) бүх шууд зардал, төлбөр, татвар, торгуул, нэхэмжлэл, 2) шууд бус алдагдал, төлбөр, татвар, хохирол, нэхэмжлэл, 3) төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон олж болох байсан ашиг.

2.1.67 "Оюуны өмч" гэж гэрээний 10.6.1-д заасан агуулгыг хэлнэ. Энэ нь ТЭЗҮ, цахилгаан станцын зураг, төлөвлөгөө, холбогдох байгууламж, дагалдах барилга, техникийн баримт бичиг, барилгын ажлын төлөвлөгөө, ашиглалтын баримт бичгүүд, хэрэглэгчийн заавар, ноу хау зэрэг бусад зүйлс,

2.1.68 "Нэрлэсэн данс" гэж Хөрөнгө оруулалтын газрын нэр дээрх Концессын данс, Төрийн сан: 9000 36 409 тоот данс, Эрчим хүчний хөгжлийн төвийн данс : Эрчим хүчний хөгжлийн төв "ТӨААТҮГ", Регистрийн дугаар 5790719, Голомт банк дансны дугаар, Ам долларын 2105012732, Төгрөгийн 2105010095 хэлнэ.

2.1. Гэрээг тайлбарлах, хэрэглэх

Гэрээг дор дурдсан зарчмын дагуу тайлбарлаж, хэрэглэнэ:

2.2.1. Гэрээний бүлэг, зүйл, заалтад тэдгээрийг хэрэглэхэд ойлгомжтой болгох зорилгоор гарчиг өгч нэрлэсэн нэр нь гэрээний агуулгыг тайлбарлахад нөлөөлөхгүй.

2.2.2. Нэг тоогоор олон тоог, олон тоогоор нэг тоог төлөөлүүлэн хэрэглэсэн тохиолдолд хэрэглэсэн тооны утгаар нь ойлгоно. Агуулгад өөрөөр заагаагүй бол нэг тоо нь олон тоог агуулж, олон тоо нь нэг тоог агуулна.

2.2.3. Гэрээнд дурдагдсан, ишлэл хийсэн хууль, тогтоол, тушаал, захирамж, удирдамж, аргачлал, адилтгах эрх зүйн баримт бичигт тэдгээрийн шинэчилсэн найруулга, оруулсан нэмэлт өөрчлөлтийг хамааруулан ойлгоно.

2.2.4. Энэ Гэрээ, түүний хавсралтад оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг гэрээ болон хавсралтад хамруулан хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр эрх зүйн баримт бичиг гэж ойлгож хэрэглэнэ.


2.2.5. Гэрээнд тусгайлан заагаагүй бол нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн техникийн болон худалдааны үг хэллэгийг нийтээр хүлээн зөвшөөрч хэрэглэдэг утгаар нь ойлгоно.

ГУРАВ. КОНЦЕССЫН ЗҮЙЛ, ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

3.1. Концессын зүйл

3.1.1. Концессын зүйл нь 1) Төслийг хэрэгжүүлэх зорилгоор эзэмшүүлж, ашиглуулах газар, 2) Концесс эзэмшигчийн өөрийн болон өөрийн боломжоор олж авсан хөрөнгөөр Цахилгаан станц барьж, ашиглалтад оруулах цахилгаан станц, 3) Түүний бүрдэл хэсэг, холбогдох байгууламж, дагалдах барилга, 4) Концессын зүйлийг ашиглах явцад үйлдвэрлэлээс цахилгаан станцын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн (эрчим хүч, уурыг оролцуулан), 5) Хатуу болон шингэн хаягдлуудаар хязгаарлагдахгүй бүх дайвар бүтээгдэхүүн, 6) Бүх бүтээгдэхүүн ба дайвар бүтээгдэхүүнийг худалдан борлуулсны орлого, 7) Цахилгаан станцын дагалдах барилга, бусад байгууламжийг түрээслүүлснээс олсон орлого, ашиг, үр шим, 8) Оюуны өмч, 9) Бусад ашиг орлого, өгөөж орно.

3.1.2 Ноу-хау, бусад төсөлтэй холбоотой оюуны өмч нь Концесс эзэмшигчийн оюуны өмч байна.

 10

3.1.3. Цахилгаан станцын иж бүрдэл хэсэг, холбогдох байгууламж, дагалдах барилгын үндсэн тоноглол, тоног төхөөрөмж, инженерийн шугам сүлжээний дэлгэрэнгүй зураглал, холболтын схем, тэдгээрийн технологийн шийдэл, техникийн үзүүлэлт, цахилгаан дамжуулах шугамыг техник эдийн засгийн үндэслэл (энэ Гэрээний хавсралт 1)- зэр тодорхойлно.

3.1.4. Төслийн барилга бүтээн байгуулалт, ашиглалтын явцад бий болсон, олж авсан цахилгаан станц, холбогдох байгууламж, дагалдах барилга (сургууль болон цэцэрлэгийг оролцуулахгүйгээр), архитектур, бүтээгдэхүүн, бусад баригдсан үл хөдлөх хөрөнгүүд нь Концесс эзэмшигчийн эзэмшилд байна.

3.2. Концессын төрөл

3.2.1. Энэ Гэрээний дагуу хэрэгжүүлэх концесс нь Концессын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, Засгийн газрын Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан хавсралтын 29 дэх хэсэгт зааснаар БАРИХ-АШИГЛАХ-ШИЛЖҮҮЛЭХ концессын төрөлд хамаарна.

3.3. Концессын гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл

3.3.1. Энэ гэрээний хавсралт гэрээнүүдийг байгуулсан нь энэхүү Концессын гэрээг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл болно. Концессын гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш 6 (зургаан) сарын дотор талууд бүх хавсралт гэрээнүүдийг байгуулж, гарын үсэг зурна.


3.3.2. Энэ гэрээг хэрэгжүүлэхэд урьдчилан хангах зайлшгүй шаардлагатай дор дурдсан нөхцөлүүдийг концесс эзэмшигч нь энэ Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 6 (зургаан) сарын дотор концесс олгогчид ирүүлж гэрээнд хавсаргасан байна. Үүнд:

- 1) энэ Гэрээний 1.3.1-1.3.6-д дурдсан дагалдах бусад гэрээнүүдийг шинэчлэн байгуулсан гэрээний эххувь;
- 2) байгаль орчны нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг Байгаль орчны тухай хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу хийлгэж, эрх бүхий байгууллагаар хянуулж, баталгаажуулсан эх хувь (энэ Гэрээний хавсралт 2);
- 3) Төслийн ерөнхий зураг төслийн эх хувь (энэ Гэрээний хавсралт 12)

3.3.3. Энэ гэрээг хэрэгжүүлэхэд урьдчилан хангах шаардлагатай дараах нөхцөлүүдийг Концесс олгогч нь энэ Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 6 (зургаан) сарын дотор хийж гүйцэтгэх үүрэгтэй.

- 1) Төслийг гүйцэтгэхэд шаардагдах хууль ёсны бичиг баримтууд: Энэ гэрээг байгуулахыг зөвшөөрсөн Засгийн газрын тогтоол.
- 2) Нүүрсний ордын нөөц хангалтыг сайжруулах нарийвчилсан төлөвлөгөөг Багануурын уурхай, орон нутгийн засаг захиргаа мөн концесс эзэмшигчтэй хамтран баталсан эх хувь.
- 3) Энэ гэрээний 3.3.2-д дурдагдсан урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэхэд концесс эзэмшигчийг бүх боломжоороо дэмжин ажиллах.

3.3.4. Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дээрх урьдчилсан нөхцөлүүд биелэгдсэн талаар концесс олгогч болон концесс эзэмшигч нь албан тоотой нөгөө талдаа мэдэгдэнэ. Албан тоотыг хүлээн авсан тал нь урьдчилсан нөхцөл биелсэн талаар ажлын 5 хоногт багтан нөгөө талдаа албан тоотой баталгаажуулж хариу өгнө. Зөвхөн хоёр тал хоёул урьдчилсан нөхцөлийг биелүүлсэн тохиолдолд талууд төслийг хэрэгжүүлэх шатанд орно.



3.4. Концессын гэрээ хэрэгжих нөхцөл

3.4.1. Энэ Гэрээ нь дор дурдсан нөхцөлийн дагуу хэрэгжинэ:

- 1) Техник эдийн засгийн үндэслэл (энэ Гэрээний хавсралт 1)-ийн дагуу энэхүү төслийг хэрэгжүүлэх ба уг баримт бичиг нь энэ Гэрээний хамт төслийн үндсэн баримт бичиг болно;
- 2) Концессын зүйлийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж батлуулах, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, хянуулах, батлуулах, барилгын материал, техник, тоног төхөөрөмж, цахилгаан станцын тоноглол, техник, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг худалдан авах, суурилуулах, угсрах, турших, ашиглалтад оруулах, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, үйлдвэрийн ашиглалтын явцын засвар, үйлчилгээний зардал болон үндсэн ба туслах тоног төхөөрөмжийн их завсар, шинэчлэлийг концесс эзэмшигч хариуцаж, эдгээрт шаардагдах хөрөнгө оруулалтын асуудлыг концесс эзэмшигч өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ;
- 3) Санхүүжилтийн хэмжээ, нөхцөл, хуваарийг энэ Гэрээний 5.6 дахь заалтын дагуу хийнэ;
- 4) Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасны дагуу гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоог хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна;
- 5) Эрчим хүчний тухай хууль, Барилгын тухай хууль болон Монгол улсын бусад хуулийн дагуу Концесс эзэмшигч доорх тусгай зөвшөөрлүүдийг эрх бүхий байгууллагуудаас авсан байна.
 1. Эрчим хүчний барилга байгууламж барьж байгуулах тусгай зөвшөөрөл,
 2. Эрчим хүчний тоног төхөөрөмжийн угсралт, тус барилга байгууламж барьж байгуулах тусгай зөвшөөрөл,
 3. Барилгын салбарын ажил, үйлчилгээний тусгай зөвшөөрөл,
 4. Төсөлтэй холбоотой тээвэрлэлтэд шаардагдах тусгай зөвшөөрлүүд.

Концесс олгогчоос олгох Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүх тусгай зөвшөөрлийн жагсаалтыг (Хавсралт 9)-д дурдав.

3.5. Концессын хугацаа

3.5.1. Концессын хугацаа нь Барилгын ажлын хугацаа болон ашиглалтын хугацааг оруулаад нийт 25 жил байх бөгөөд энэ Гэрээний дагуу талууд хамтран баталгаажуулсан хугацаагаар сунгагдана.

3.5.2. Концессын хугацааг (i) санхүүжилтийн гэрээ байгуулагдсан ба (ii) Төслийн барилгын ажлын зөвшөөрөл олгогдсоны аль сүүлд биелсэн өдрөөс тооцно.

3.5.3. Цахилгаан станцын эхний блокыг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж тасралтгүй 72 цагийн туршилт хийгдэж дууссан өдрөөр барилгын ажил дуусна.

3.5.4. Цахилгаан станцын эхний блокыг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж тасралтгүй 72 цагийн туршилт хийгдэж дууссаны дараахь өдөр ашиглалтын хугацааг тооцож эхэлнэ.

3.6. Концессын гэрээ хүчин төгөлдөр болох

3.6.1. Энэ Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар уг гэрээний талууд хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх бүрэн



эрх, хууль ёсны итгэмжлэлтэй болохоо харилцан баталгаажуулсанд тооцно. Талуудын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн итгэмжлэл нь (Хавсралт 16) болж гэрээнд хавсаргана.

3.6.2. Гэрээнд талууд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно. Гэрээний 3.3-т заасан концессын гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл хангагдсанаар энэхүү гэрээг талууд хэрэгжүүлж эхлэх болно. Концесс эзэмшигч нь (Хавсралт 3, 11, 12, 15 –аас бусад) гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл хангагдах хүртэл гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйг нь энэ гэрээг зөрчсөнд тооцогдохгүй.

3.7. Концессын хугацааг сунгах

3.7.1. Барилгын болон ашиглалтын ажлын хугацааг сунгасан нь Концессын хугацаа мөн хугацаагаар сунгагдана.

3.7.2. Барилгын ажлын хугацааг дараах тохиолдолд сунгаж болно:

- 1) төрийн байгууллагаас шалтгаалж, концессын гэрээнд заасан үйл ажиллагаа тасалдсан, хойшлогдсон;
- 2) гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр концессын гэрээнд заасан үйл ажиллагаа тасалдсан, хойшлогдсон;
- 3) эрх бүхий байгууллага, засгийн газрын хүсэлт, шаардлагаар концессын хөрөнгө оруулалт нэмэгдсэн, эсвэл төслийн зураг төсөл өөрчлөгдсөн,
- 4) энэ гэрээнд заасан цаг хугацаанд концесс олгогч нь өөрийн үүргийг биелүүлээгүйн улмаас газар, ус, дулаан, интернет, холбоо, кабел, бохир ус зайлуулах, гэх мэтийг ашиглах нь хойшлогдсон, эсвэл холбогдох зөвшөөрлийг авах нь хойшлогдсон,
- 5) хөрш зэргэлдээ оршин суугчид, Засгийн газрын байгууллагууд, бусад байгууллага, аж ахуйн нэгжийн байгууллагуудын учруулсан саад нь барилгын ажлын явцад нөлөөлсөнийг баримтаар нотлогдсоныг Концесс олгогч хүлээн зөвшөөрсөн,
- 6) хэрэв Засгийн газар болон Заалт 1.2-т зааснаар үл хязгаарлагдах холбогдох зохицуулах байгууллагууд нь төслийн барилгын ажилд шаардлагатай зөвшөөрөл, шаардлагатай баримт бичгийг гаргаагүй эсвэл хойшлогдсон,
- 7) түүхийн үнэт зүйлс, байгалийн баялаг, шинжлэх ухааны нээлт, чулуужсан малтмал зэрэг нь төслийн газарт илрэн, барилгын ажил хойшлогдоход хүрсэн,
- 8) концесс эзэмшигчийн зүгээс санал болгосон зураг төслийн өөрчлөлт концесс олгогчоор зөвшөөрөгдсөн,
- 9) концесс олгогч нь энэ гэрээнд хүлээсэн өөрийн үүргийг биелүүлээгүйн улмаас барилгын ажил хойшлогдсон.

Барилгын ажлын хугацаа сунгагдсан тохиолдолд Концессын хугацаа мөн хугацаагаар сунгагдана.

3.7.3. Концессын ашиглалтын хугацааг дараах тохиолдолд сунгаж болно.

- 1) төрийн байгууллагаас шалтгаалж, концессын гэрээнд заасан үйл ажиллагаа тасалдсан, хойшлогдсон бол тухайн хугацаагаар;
- 2) гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр концессын гэрээнд заасан үйл ажиллагаа хэрэгжих боломжгүй болсноор энэ Гэрээний хугацаа тасалдсан, хойшлогдсон боловч тухайн нөхцөл байдал арилсанаар гэрээ хэрэгжих боломжтой болсон бол тасалдсан, хойшлогдсон хугацаагаар;
- 3) урьдаас төсөөлөөгүй нөхцөл байдал үүссэн нь концесс эзэмшигчид санхүүгийн хүндрэл үүсгэсэн эсвэл татвар, хураамж, зардал нэмэгдэх,



ард түмэнд төлбөр төлөөс төлөхөд хүргэсэн тохиолдолд концесс олгогч нь концессын хугацааг сунгана.


- 4) эрх бүхий этгээд, Засгийн газрын шаардлага, хүсэлтээр концессын хөрөнгө оруулалтын дүн нэмэгдсэн тохиолдолд концесс эзэмшигч нэмэгдсэн төсвийг олох болон алдагдлыг нөхөхөд хангалттай хугацаагаар концессын хугацааг сунгахыг баталгаажуулна.
- 5) энэ гэрээнд заасан цаг хугацаанд концесс олгогч нь өөрийн үүргийг биелүүлээгүйн улмаас газар, ус, дулаан, интернет, холбоо, кабел, бохир ус зайлуулах, гэх мэтийг ашиглах нь хойшлогдсон, эсвэл холбогдох зөвшөөрлийг авах нь хойшлогдсон тохиолдолд алдагдсан алдагдлыг нөхөх зорилгоор энэ хоцорсон эсвэл түүнээс урт хугацаагаар сунгана.
- 6) хэрэв нүүрс нь хангалттай хэмжээгээр нийлүүлэгдээгүй, нүүрсний чанар нь нүүрс худалдах, худалдан авах гэрээнд заасан хэмжээнд хүрээгүй, эсвэл нүүрсний уурхайн олборлолтын хүчин чадал нь заасан хугацаанд хийгдээгүйн улмаас нүүрсний нийлүүлэлт хангалтгүй байсан эсвэл энэ гэрээнд заасан бүтээгдэхүүн үйлдвэрт төлөвлөгөөндөө хүрээгүй бөгөөд Багануурын нүүрсний уурхай нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу Концесс эзэмшигчид нөхөн төлбөр олгож чадахгүй тохиолдолд концессын хугацааг сунгана.
- 7) Эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний дагуу худалдан авагч нь гэрээнд заасан тоо хэмжээний эрчим хүчийг худалдан аваагүй бөгөөд Эрчим хүч худалдах, худалдан авах гэрээнд заасны дагуу нөхөн төлбөрийг олгоогүй тохиолдолд концесс олгогч нь концесс эзэмшигчийн алдагдлыг гэрээнд заасан хэмжээний борлуулалт хүртэл нөхөн олгох хэмжээгээр, эсвэл Концесс эзэмшигч зөвшөөрсөн ба зөвхөн Концесс эзэмшигчийн хүсэлтээр концессын хугацааг сунгана.
- 8) Хэрэв хөрш зэргэлдээ оршин суугчид, засгийн газрын байгууллагууд, бусад байгууллага, аж ахуйн нэгжийн байгууллагуудын учруулсан саад тотгор, садааны улмаас төслийн ашиглалтад сөргөөр нөлөөлсөний баримтаар нотлогдсоныг Концесс олгогч хүлээн зөвшөөрсөн тохиолдолд сунгана.
- 9) хэрэв Засгийн газар болон Заалт 1.2-т зааснаар үл хязгаарлагдах холбогдох зохицуулах байгууллагууд нь төслийн ашиглалтын ажилд шаардлагатай зөвшөөрөл, шаардлагатай баримт бичгийг гаргаагүй эсвэл хойшлогдсон тохиолдолд концесс эзэмшигчид учирсан сөрөг үр дагаврыг арилгах хэмжээнд сунгана.
- 10) түүхийн үнэт зүйлс, байгалийн баялаг, шинжлэх ухааны нээлт, чулуужсан малтмал зэрэг нь төслийн газарт илрэн, төслийн ашиглалтын ажилд сөргөөр нөлөөлсөн тохиолдолд сунгана.
- 11) концесс олгогч нь энэ гэрээнд хүлээсэн өөрийн үүргийг биелүүлээгүйн улмаас концесс эзэмшигчид хохирол учирсан тохиолдолд,

Станцын ашиглалтын хугацаа сунгагдсан тохиолдолд Концессын хугацаа мөн хугацаагаар сунгагдана.

3.7.4. Концесс эзэмшигч өөрийн буруутай үйл ажиллагаанаас концессын санхүүжилтийг нөхөх хэмжээний ашигтай ажиллаж чадаагүй нь энэ гэрээг сунгах үндэслэл болохгүй.

3.7.5. Цахилгаан станцын ТЭЗҮ-д тооцоологдсон үнэ нь эрчим хүчний тухай хуулийн дагуу үнэ өөрчлөгдсөн тохиолдолд концесс олгогч, концесс эзэмшигч талууд Эрчим хүчний зохицуулах хорооны зөвшөөрлөөр энэ Гэрээний 3.5.1-д заасан хугацаанд өөрчлөлт оруулж өсгөж болно.

3.7.6. Энэ Гэрээний 3.7.2, 3.7.3 -т заасан гэрээний сунгалтын хугацаа нь



дээр заасан нөхцөл байдлуудаас үүссэн концесс эзэмшигчид учирсан хохирлыг нөхөхөд хангалттай хүрэлцэхүйц урт байна.

3.8. Концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

3.8.1. Талууд харилцан тохиролцож, энэ гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

3.8.2. Концесс эзэмшигч Концессын тухай Монгол улсын хуулийн 23.2, 23.3 дугаар зүйлд заасны дагуу гэрээний нөхцөлийг өөрчлөх санал гаргах эрхтэй.

3.8.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болсон тохиолдолд талууд дараах журмыг баримтална:

1) нэмэлт өөрчлөлт оруулах мэдэгдэл, саналаа тусгасан гэрээний төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөж буй өдрөөс хуанлийн 30-аас доошгүй хоногийн дотор санал гаргагч тал нөгөө талдаа бичгээр, биечлэн эсхүл албан ёсны харилцаандаа хэрэглэж заншсан холбоо харилцааны хэрэгслээр хүргүүлж, энэ талаар нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээдэд заавал мэдэгдэнэ.

2) мэдэгдэл, санал хүргүүлснээс хойш хуанлийн 30 хоногийн дотор саналыг хүлээн авсан тал саналыг зөвшөөрч, эс зөвшөөрч байгаа эсэх талаараа хариу мэдэгдэл, саналыг энэ хэсгийн 1-д заасны дагуу буцаан хүргүүлнэ.

3.8.4. Талууд санал нэгдсэн тохиолдолд энэ Гэрээний нэмэлт, өөрчлөлтийг үйлдэж, гарын үсэг зурж, баталгаажуулснаар мөрдөж эхэлнэ.

3.8.5. Мэдэгдэл, саналын дагуу талууд өөр байр суурьтай байгаа тохиолдолд санал гаргасан тал уулзалт зохион байгуулж, энэ талаар харилцан зөвшилцөлд хүрэх шаардлагатай бүхий л арга хэмжээг хамтарч авна.

3.8.6. Талууд тохиролцоонд хүрч эс чадвал санал гаргагч тал тавьсан саналаа хэвээр үлдээх, аль эсхүл уг саналаасаа татгалзах талаар өөрийн байр суурийг нөгөө талдаа дахин бичгээр хүргүүлнэ.

3.9. Концесс эзэмшигчийн онцгой эрх

3.9.1. Концесс эзэмшигч нь гэрээний 3.1-д заасан концессын зүйлийг эзэмших, хэрэглэх, ашиглах, ашиг орлого олох эрхтэй байна. Тодруулбал концесс эзэмшигч нь дараах болон бусад эрхүүдийг эдэлнэ.

- 1) Энэ гэрээнд заасны дагуу олох бүх ашгийг Концесс эзэмшигч өмчлөх эрхэнд хязгаар тогтоохгүй.
- 2) Концесс эзэмшигчийн концессын зүйлийн материаллаг өмчийг өмчлөх эрх нь дараах нөхцөлөөр хязгаарлагдана. Концесс эзэмшигч нь эдгээр өмчийг Концессын гэрээний хугацаанд зарах, бэлэглэх, эсвэл шилжүүлэхийг хориглоно.
- 3) Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай газрыг ашиглах эрх нь баталгаажсан байх ба энэ газар нь цахилгаан станц, холбогдох байгууламж, дагалдах барилгын газар байна. Энэхүү газар дээр төслийг хэрэгжүүлэх зорилгоор дээрх барилга, байгууламжуудыг барьж байгуулах.
- 4) Гэрээнд заасны дагуу цахилгаан станцыг эзэмших, хэрэглэх, ашиглах, ашиг орлого олох, барьцаалах, шилжүүлэх,
- 5) Тоглоомын талбай, орон сууцны барилга, үйлчилгээний төвүүдийг өмчлөх, эзэмших, хэрэглэх, ашиглах, ашиг орлого олох, барьцаалах мөн шилжүүлэх эрхтэй. Сургууль болон цэцэрлэгийг концесс эзэмшигч барьж байгуулан, дуусгаснаар Концесс олгогчид шилжүүлэн өгнө.



Концесс олгогч нь сургууль, цэцэрлэгийг эзэмших бөгөөд холбогдох хариуцлага, эрсдэлийг Концесс олгогч өөрөө хариуцна.

б) Концесс эзэмшигч нь хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон бусад эд хөрөнгийг өмчлөх, эзэмших, хэрэглэх, ашиглах, ашиг орлого олох эрхтэй байна.

3.9.2. Энэ Гэрээний 3.1-т заасан концессын зүйлээс олсон, бий болсон хөрөнгө, орлого, олсон ашиг, үр шим нь концесс эзэмшигчийн өмч байна. Төслийн барилга бүтээн байгуулалт, ашиглалтын явцад бий болсон, олж авсан цахилгаан станц, холбогдох байгууламж, дагалдах барилга (сургууль болон цэцэрлэгийг оролцуулахгүйгээр), архитектур, бүтээгдэхүүн, бусад баригдсан үл хөдлөх хөрөнгө нь Концесс эзэмшигчийн хөрөнгө байна.

3.9.3. Концесс эзэмшигч нь цахилгаан станцын засгийн газраас зөвшөөрөл шаардагдах цахилгаан эрчим хүч, дулаанаас бусад бүх бүтээгдэхүүний үнэтариф болон нөхцөлийг тогтоох эрхтэй байна. Концессын зүйлийн дагалдах барилгыг, (сургууль цэцэрлэгийг оролцуулахгүйгээр) нэмэгдэл орлого олох зорилгоор олон нийтэд ашиглуулахдаа үнэ тариф болон нөхцөлийг концесс эзэмшигч тогтоох эрхтэй байна.

3.9.4. Концесс эзэмшигч нь концессын зүйлийг барьж байгуулахтай холбоотой хөрөнгө оруулалтыг олох, бий болсон концессын зүйлийг хэвийн ажиллуулах, өргөжүүлэх, хөгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг олоход концессын зүйлийг концесс олгогчийн зөвшөөрснөөр барьцаалах эрхтэй байна.

3.9.5. Концессын зүйлийн оюуны өмч болох цахилгаан станц, түүний холбогдох байгууламж, дагалдах барилгын зураг төсөл, технологийн баримт бичиг, ашиглалтын зааварчилгаа, ноу-хау нь концесс эзэмшигчийн өмч байна. Концессын зүйлийг концесс олгогчид шилжүүлж өгснөөр концесс эзэмшигч нь төслийн насжилтын хүрээнд ашиглалт болон засвар үйлчилгээг хийх зорилгоор оюуны өмч болон ноу-хауг ашиглах хязгаарлагдмал эрхийг концесс олгогчид олгоно.

3.9.6. Концесс эзэмшигч нь концессын гэрээний хугацаа дуусахад концессын зүйлийг (үүнд ашиг, орлого, үр шим, оюуны өмч болон хүлээлгэн өгөх хөтөлбөрт тусгагдаагүй бусад зүйлс хамаарахгүй) нь төрийн өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлнэ.

3.10. Концесс эзэмшигчид хориглох зүйл

3.10.1. Концесс олгогчийн зөвшөөрөлгүйгээр концесс эзэмшигч нь гуравдагч этгээдэд концессын зүйлийг бэлэглэх, арилжих, худалдах зэргээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

3.10.2. Төслийг санхүүжүүлэхээс бусад тохиолдолд концесс эзэмшигч концесс олгогчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дараах үйлдлүүдийг хийхийг хориглоно. Үүнд:

- 1) концессын зүйлийн аль ч хэсгийг барьцаалах;
- 2) концесс эзэмшигчийн хяналтын багцаа худалдах, концессын зүйлийг эзэмших эрх, үүргийг гуравдагч этгээдэд шилжүүлэх;
- 3) өөрчлөн зохион байгуулагдах замаар төслийн хяналтын багцаа алдах хэмжээнд концесс эзэмшигчийн эрх, үүргээ шилжүүлэх;
- 4) Гадаадын болон Монголын хөрөнгийн биржид гарах замаар олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох, концесс эзэмшигчийн хувьцаагаа зах зээлд худалдах, үнэт цаас гаргах, арилжаалах;
- 5) Концесс эзэмшигчийн хувь нийлүүлэгчийг өөрчилж, энэ өөрчлөлттэй холбогдуулан гуравдагч этгээдтэй гэрээ, хэлцэл

байгуулах;

б) Гэрээнд бусдад шилжүүлэхийг хориглосныг зөрчин энэ гэрээгээр тохиролцсон болон техник эдийн засгийн үндэслэлийн дагуу гүйцэтгэх ажлыг тасалдуулах, өөр этгээдэд шилжүүлэх.

3.10.3. Концессын зүйлийг бусдад шилжүүлэхдээ энэ Гэрээний 3.10.2-р зүйл болон Концессын тухай Монгол улсын хуулийн 27, 32 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

3.10.4. Концесс эзэмшигч нь санхүүжүүлэгчтэй хийсэн санхүүгийн гэрээний дагуу Төслийг шилжүүлэх тохиолдолд санхүүжүүлэгч тал, Концесс олгогчийн зөвшөөрөлтэйгөөр, Төслийг хүлээн авахаар гуравдагч этгээдийг томилох эрхтэй.

3.11. Концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих

3.11.1. Энэ Гэрээний хэрэгжилтэд концесс олгогч болон энэ Гэрээний ерөнхий зүйлд заагдсан зохицуулах байгууллагууд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

3.11.2. Концесс олгогч болон концесс эзэмшигч нь хамтран төслийн хэрэгжилтэд хяналт тавих мэргэжлийн өндөр ур чадвартай бие даасан инженер томилон ажиллуулах ба концесс эзэмшигч нь бие даасан инженертэй хяналтын гэрээ байгуулж ажиллана. Ажлын хуваарь, хийгдэх ажлын төлөвлөгөө, тайлагнах хугацааг концесс эзэмшигчтэй тохиролцсоны үндсэн дээр боловсруулна. Хяналтын зардлын хэмжээг хяналтын гэрээнд тусгах ба энэ зардлыг концесс эзэмшигч санхүүжүүлнэ.

3.11.3. Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл олгохдоо Эрчим хүчний тухай хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь концесс эзэмшигч техник эдийн засгийн үндэслэлд заасан технологийн шаардлагыг хангах үндсэн болон туслах өмнө ашиглагдаж байгаагүй, ашиглалтаас хасагдаагүй, цаашид удаан жил хэвийн ажиллах боломжтой техник тоног төхөөрөмжийг сонгож чадсан эсэх, хөрөнгө оруулалт, орлого, зарлага, үр ашгийн тооцоо нь үндэслэлтэй хийгдсэн эсэх, санхүүгийн чадавхтай, боловсон хүчин, ажлын дадлага хангалттай байгаа эсэхийг нарийн шалгаж, зөвшөөрөл олгох ба тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын хэрэгжилтэд тухайн байгууллага хяналт тавьж, эдгээр нөхцөл шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд хариуцлага хүлээлгэж ажиллана.

3.11.4. Барилгын ажил үйлчилгээ эрхлэх, эрчим хүчний барилга угсралт барих тусгай зөвшөөрлийг төслийн гүйцэтгэгчид олгохдоо Барилгын асуудал эрхэлсэн болон Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон харьяа байгууллагууд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд концесс эзэмшигчид хууль тогтоомжийн шаардлага, шалгуурт нийцсэн зураг төсөл, техникийн нөхцөл, шаардлагаар ажиллах эсэх, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, норм, нормативын шаардлагыг хэрхэн хангаж байгааг шалгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

3.11.5. ТЭЗҮ (энэ Гэрээний хавсралт 1)-д тусгагдсан техник, технологийн болон бусад нөхцөлийн хэрэгжилтэд Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

3.11.6. Барилга байгууламжийн зураг төсөл нь Барилгын тухай, Эрчим хүчний тухай Монгол улсын хууль тогтоомж, стандартад нийцсэн эсэхэд эрчим хүчний болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

3.11.7. Барилгын ажлын үе шатны ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх,

үйлдвэрлэлийг турших, хэвийн ажиллагааг жигдрүүлэх цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тогтоосон техникийн нөхцөл, шаардлага, аюулгүй ажиллагааны дүрэм, журам, норм, нормативыг техникийн шаардлагыг хангаж байгаа эсэхэд Эрчим хүчний болон Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон тэдгээрийн харъяа байгууллагууд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд хяналт тавьж ажиллана.

3.11.8. Энэ гэрээгээр концесс эзэмшигч хийхээр тохирсон ажил үйлчилгээг холбогдох Монгол Улсын хуультогтоомж, техник эдийн засгийн үндэслэлд заасан нөхцөл шаардлагын дагуу тогтоосон хугацаанд гүйцэтгэгдэж байгаа эсэх, шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилт хуваарийн дагуу хэвийн хийгдэж байгаа эсэхэд концесс олгогч хяналт тавина.

3.11.9. Бие даасан инженер барилгын ажлын явцад зөрчил илрүүлсэн тохиолдолд концесс эзэмшигчид бичгээр мэдэгдэх бөгөөд гуч (30) хоногийн дотор Концесс эзэмшигч зөрчлийг арилгаагүй бол бие даасан инженер Концесс олгогчид мэдээлж болно. Хэрэв Концесс олгогч болон концесс эзэмшигч тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд асуудлыг шийдвэрлэхдээ талууд концесс эзэмшигчийн зардлаар хөндлөнгийн шинжээч томилно.

3.11.10. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний орон нутаг дахь салбар байгууллагууд хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

3.11.11. Бие даасан инженер нь цахилгаан станцыг ашиглалтад оруулах ажлыг хянан хийх болно.

3.11.12. Цахилгаан станцын ашиглалт, үйлдвэрлэлийн явцад Эрчим хүчний тухай хууль тогтоомж, тогтоосон дүрэм, журмыг баримтлан ажиллаж байгаа эсэхэд Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

3.11.13. Үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг нийлүүлэх үнэ тарифыг Эрчим хүчний тухай хууль тогтоомжид заасан аргачлал, журмын дагуу эрчим хүчний үнэ тариф, зохицуулалт хариуцсан зохицуулах байгууллага энэ гэрээнд суурилж баталж, биелэлтэд хяналт тавина.

3.12. Санхүүгийн хаалтын баталгаа ба Гүйцэтгэлийн баталгаа

3.12.1. Санхүүгийн хаалтын баталгаа

3.12.1.1. Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 30 (гуч) өдрийн дотор 3 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний Тендерийн баталгааны хүчинтэй хугацааг Санхүүгийн хаалтын баталгааны хугацаа дуусах хүртэл сунгана.

3.12.1.2. Санхүүгийн хаалтын баталгаа нь Барилгын ажил эхлэх өдрөөр дуусгавар болох бөгөөд Гэрээний 3.12.2.-д заасан баталгааг Концесс олгогчид гаргахыг баталгаажуулна. Санхүүгийн хаалтын баталгаа нь Концесс олгогчид Гүйцэтгэлийн баталгааг илгээснээр чөлөөлөгдөнө.

3.12.1.3. Санхүүгийн хаалтын баталгааг Монгол улсын арилжааны банк эсвэл олон улсын банкнаас гаргана.

3.12.1.4. Санхүүгийн хаалтын баталгаа нь шаардлагатай үед үл маргах, үл буцаах нөхцөлөөр банкнаас төлөгдөнө.

3.12.2. Гүйцэтгэлийн баталгаа

3.12.2.1. Гэрээний 3.3-д заасан урьдчилсан нөхцөл биелэх тохиолдолд, Барилгын ажлын эхэлсэн өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор 10,000,000

(арван сая) ам.долларын баталгааг Концесс олгогчид гаргана.

3.12.2.2. Гүйцэтгэлийн баталгаа нь барилгын ажил бүрэн дууссан өдрөөс хойш 30 (гуч) хоногт дуусгавар болно. Гүйцэтгэлийн баталгаа нь барилгын ажил бүрэн дууссан өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор чөлөөлөгдөнө.

3.12.2.3. Гүйцэтгэлийн баталгааг Монгол улсын арилжааны банк эсвэл олон улсын банкнаас гаргана.

3.12.2.4. Гүйцэтгэлийн баталгаа нь шаардлагатай үед үл маргах, үл буцаах нөхцөлөөр банкнаас төлөгдөнө.

3.12.3. Концесс олгогч нь аливаа арга хэмжээ авах эсэхээс үл хамааран дараах эрхтэй.

3.12.3.1. Хэрэв Концесс эзэмшигч нь 3.12.1.1-д заасан хугацаанд санхүүгийн хаалтын баталгаа гаргаагүй тохиолдолд тендерийн баталгааг гүйцэтгүүлнэ.

3.12.3.2. Хэрэв Концесс эзэмшигч нь гүйцэтгэлийн баталгааг 3.12.2.1-д заасан хугацаанд гаргаагүй тохиолдолд санхүүгийн хаалтын баталгааг гүйцэтгүүлнэ.

3.12.3.3. Хэрэв Концесс эзэмшигчийн буруутай үйлдлээс шалтгаалан Барилгын ажлын 4 жилийн дотор барилгын ажил бүрэн дуусаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгааг бүрэн хэмжээгээр гүйцэтгүүлнэ.

3.12.3.4. Хэрэв Концесс олгогч нь 7.2.1.2, ба 7.3.1,-д заасны дагуу Гэрээг цуцлах эрх үүссэн тохиолдолд Концесс олгогч тооцоологдсон хохирлын хэмжээг 8.1.2 2)-ын дагуу гүйцэтгэлийн баталгаанаас хасч болно.

3.13. Концессын төлбөр

3.13.1. Концесс эзэмшигч нь Концессын тухай хуулийн 26.4.2-д заасны дагуу концесс олгогчид 3,000,000 (гурван сая) ам.долларын хэмжээний концессын төлбөрийг доорх графикийн дагуу эрх бүхий этгээдийн нэрлэсэн дансанд төлнө.

- (1) Санхүүгийн хаалтын дараагаар 45 хуанлийн өдрийн дотор 600,000 ам доллар төлөгдөнө.
- (2) Барилгын зөвшөөрөл гарснаар 45 хуанлийн өдрийн дотор 600,000 ам доллар төлөгдөнө.
- (3) Барилгын ажил эхэлснээс 1 жилийн дараагаар 600,000 ам доллар төлөгдөнө.
- (4) Барилгын ажил эхэлснээс 2 жилийн дараагаар 600,000 ам доллар төлөгдөнө.
- (5) Барилгын ажил эхэлснээс 3 жилийн дараагаар 600,000 ам доллар төлөгдөнө.

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Концесс олгогчийн эрх, үүрэг

4.1.1. Концесс олгогч Концессын тухай Монгол улсын хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна дараах эрх эдэлнэ:

- 1) энэ Гэрээгээр тохиролцсон, ТЭЗҮ-д тусгагдсан техник, технологи, хүчин чадал бүхий ДЦС-ыг барьж ашиглахыг концесс эзэмшигчээс шаардах;
- 2) хууль буюу энэ Гэрээнд заасан үндэслэлээр энэ Гэрээг цуцлах, концесс эзэмшигчийн эрх, үүргийг түр шилжүүлэн авах, концесс эзэмшигчийг өөрчлөх, концессын зүйлийг шилжүүлэн авах;
- 3) концессын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих явцад шаардлагатай гэж үзвэл концесс олгогч нь концесс эзэмшигчийн зөвшөөрөлтэйгөөр хөндлөнгийн мэргэжлийн шинжээчийн багаар хөндлөнгийн,



мэргэжлийн дүгнэлтийг гаргуулах,

4) концессын гэрээ хэрэгжих урьдчилсан нөхцөл болон энэ гэрээнд заасан бусад нөхцөлийг хангуулах талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг авах;

5) цахилгаан станцын техник, тоног төхөөрөмж, материалын чанар, технологийн үзүүлэлтүүд нь хавсралт 15-д заасны дагуу олон улсын болон Монголын стандарт, норм хэмжээг хангасан байхыг шаардах,

6) хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээ нэмэгдэх шаардлагатай гэж концесс эзэмшигч үзсэн ба энэ нь цахилгаан, эрчим хүчний үнэнд өөрчлөлт оруулахуйц тохиолдолд концесс олгогч нь нэмэгдэх болсон шалтгаан, үндэслэлийг концесс эзэмшигчээр тухай бүр гаргуулж авах, хянан үзэж Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлэх;

7) энэ Гэрээний 3.10 дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд гэрээ хэлцлийг хүчингүй болгохыг шаардах, концесс эзэмшигч гэрээг зөрчсөн гэж үзвэл гэрээний 7.2 дэх хэсэгт заасны дагуу гэрээг цуцлахыг шаардах;

8) энэ Гэрээний биелэлтэд хяналт тавих зорилгоор өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг Концесс эзэмшигчтэй тохиролцож, хяналтын гэрээ (энэ Гэрээний хавсралт №10)-ний дагуу Концесс эзэмшигчийн зардлаар томилон ажиллуулах;

9) цахилгаан станц, холбогдох байгууламж, дагалдах барилгыг төрд хүлээлгэн өгөх үед станцын ашиглалт, угсралтын баримт бичиг, заавар, зааварчилгаа, ашиглалтын ноу хауг хувилж авах, түүнчлэн концессын зүйлийг хүлээн авах үед тэдгээрийг эх хувиар нь нууцлалын кодын хамт бүрэн шилжүүлж авах;

10) концессын зүйлийг энэ Гэрээний 5.4-т заасан даатгалд заавал даатгуулахыг шаардах;

11) барилгын ажлын үе шатны ажлын төлөвлөгөөнд тусгасан хуваарь зөрчигдсөн тохиолдолд шалтгааныг тодруулах, цаашид хуваарийн дагуу хийж гүйцэтгэх талаар зөвлөх, сануулах, зөрчигдсэн шалтгааныг арилгах, шийдлийг олоход концесс эзэмшигчтэй хамтран ажиллах.

4.1.2. Концесс олгогч дараах үүрэг хүлээнэ:

1) концесс эзэмшигчийн буруугаас энэ гэрээг хэрэгжүүлэх нөхцөлийг хугацаанд нь хэрэгжүүлж чадаагүй, станц, холбогдох байгууламж, дагалдах барилгыг барих ажлын хуваарь зөрчигдсэн, алдагдсан зэрэг нь энэ гэрээг цуцлах хэмжээний зөрчил биш гэж үзсэн тохиолдолд концесс эзэмшигчид сануулах,

2) зам, нүүрс, ус, кабел, холбоо, бохир ус зайлуулах, дулаан болон цахилгааны дэд бүтцийг байгуулахад орон нутаг, төмөр зам болон бусад эрх бүхий байгууллагуудтай хууль зүйн хүрээнд хамтран ажиллах, нүүрсний үнийг тогтвортой байлгах, цахилгаан станц барьж байгуулах явцад төвийн эрчим хүчнээс цахилгаан худалдан авч ашиглах нөхцөлд үнийг тогтвортой байлгах чиглэлээр зохицуулах байгууллагууд болон орон нутгийн эрх бүхий байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах. Концесс олгогч нь холбогдох талуудтай эдгээр асуудлыг зохицуулан ажиллана


3) Төслийг хэрэгжүүлэхийн тулд, холбогдох зөвшөөрлүүд, газрын ашиглалт, татвар/хураамжийн хөнгөлөлт болон бусад дэмжлэг үзүүлэх салбарууд болох усны хэрэглээ, кабел холбоо, гадаад ажилчдын зөвшөөрөл гэх мэт асуудлаар Монгол улсын Концессын тухай хуулийн 21.1.8, 30.1.3 дугаар зүйлд болон бусад холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу дэмжлэгийг концесс эзэмшигчид үзүүлэх,

- эдгээртэй холбоотой Засгийн газраас шийдвэрлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдүүлэх талаар санал хүргүүлэх;
- 4) Гэрээний хавсралтуудыг боловсруулахад концесс эзэмшигчид дэмжлэг үзүүлэх, байгуулах шийдвэр гаргуулах;
- 5) энэ Гэрээний 3.7-д заасны дагуу концессын гэрээг сунгах нөхцөл үүссэн тохиолдолд Засгийн газарт танилцуулан холбогдох шийдвэр гаргуулах;
- 6) Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч Гэрээний хугацааг сунгахгүйгээр шийдвэрлэсэн бол холбогдох нөхөн олговрыг энэ Гэрээний 7.9 болон 3.7-д заасны дагуу тооцож олгох;
- 7) дагалдах бусад гэрээний концесс олгогчийн тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд концесс олгогч нь эдгээр гэрээнүүд бүрэн хэрэгжих, залруулах арга хэмжээг яаралтай авч, концесс эзэмшигчийн хохирлыг барагдуулах арга хэмжээг авах.
- 8) Концесс олгогч нь Багануурын нүүрсний уурхай нь Нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу цахилгаан станцын үр ашигтай үйл ажиллагаанд нийцсэн тоо хэмжээний болон чанарын тодорхой түвшний нүүрс нийлүүлэх хэмжээнд нүүрс олборлох хүчин чадлаа нэмэгдүүлэхийг баталгаажуулна.
- 9) Концесс олгогч Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээнд заасан хэмжээний цахилгаан эрчим хүчийг худалдан авах баталгааг гаргана.
- 10) Төслийн газар нь газрын төлөвлөлт хийж буй эрх бүхий байгууллагуудын тогтоосны дагуу зориулалтын дагуу ашиглагдах ба концессын хугацааны явцад ямар нэгэн саад, хүндрэл үүсэхгүй гэдгийг концесс олгогч баталгаажуулна.
- 11) Концессын хугацаанд жил бүр төслийн хэрэгжилтэд шаардлагатай гадаад техникийн болон менежементийн ажилчдын ажиллах зөвшөөрлийн квотыг концесс олгогч олгож баталгаажуулна.
- 12) Концесс олгогч Төслийн хүрээнд хийгдэх тээвэрлэлтэд шаардлагатай тусгай зөвшөөрлүүд авахыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд баталгаажуулж, Концесс эзэмшигчид шаардлагатай бүх туслалцааг үзүүлнэ.
- 13) Концесс олгогч, зохицуулагч эрх бүхий байгууллагуудын төлөөлөгч, томилогдсон этгээд нь энэ гэрээ болон хуулийн дагуу явагдаж буй барилгын ажил, ашиглалтын ажиллагаанд хууль бусаар саад учруулж зогсоохгүй байх.
- 14) Монгол улсын Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу Концесс эзэмшигч, Засгийн газархооронд Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж болно.
- 15) Концесс олгогч Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад бүх зөвшөөрлүүдийг авахад баталгаа гаргаж Концесс эзэмшигчид бүх талын дэмжлэг туслалцааг үзүүлнэ.

4.2. Концесс эзэмшигчийн эрх, үүрэг

4.2.1. Энэ Гэрээний 3.9-т заасан онцгой эрхээс гадна концесс эзэмшигч дараах эрх эдэлнэ:

- 1) концесс олгогчоос энэ гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах;
- 2) концессын гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл олж авах, дагалдах гэрээ хэлцлийг богино хугацаанд байгуулахад концесс олгогчоос холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг, туслалцаа авах;



- 3) энэ гэрээнд заасан нөхцөл, ажил үйлчилгээг өөрчлөх санал гаргах;
- 4) техник технологийн схемд нэмэлт өөрчлөлт, оруулах зэрэг аливаа техникийн өөрчлөлтийн асуудлыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;
- 5) нийтийн зориулалтаар ашиглагдаж болох концессын зүйлийг нэмэгдэл орлого олох зорилгоор ашиглах, энэ тохиолдолд үнэ тарифыг өөрөө тогтоох;
- 6) энэ гэрээгээр хориглосон, тусгайлан зөвшөөрсөнөөс бусад асуудлыг бие даан шийдвэрлэх, аж ахуйн үйл ажиллагаагаа хууль тогтоомжийн хүрээнд чөлөөтэй эрхлэх;
- 7) концессын гэрээний хугацаа дуусгавар болсны дараа концесс олгогч зөвшөөрснөөр цахилгаан станц ашиглах чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгөх, засвар үйлчилгээ хийх ажил үйлчилгээ хийж болно;
- 8) гадаад валютыг чөлөөтэй хөрвүүлэх, гадаад улс орон уруу чөлөөтэй шилжүүлэх;
- 9) төслийн зориулалтаар газрыг ямар нэгэн саадгүйгээр ашиглах;
- 10) концессын төслийг хэрэгжүүлэх зорилгоор зураг төсөл, хяналт, ханган нийлүүлэлт, барилга, ашиглалт, засвар үйлчилгээ болон бусад холбогдох гэрээ хэлэлцээрийг гуравдагч этгээдтэй хийх эрхтэй байна.
- 11) Төслийн барилгын ажлын үед тодорхой тооны дотоодын ажиллах хүчийг оролцуулах, станцын үйл ажиллагааны үед гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн авч буй өндөр ур чадвар, нарийн мэргэшил шаардсан ажлын байранд дотоодын ажиллах хүчийг дагалдуулан ажиллуулж, мэргэшүүлэх;
- 12) Концесс эзэмшигч материалын дизайны өөрчлөлтийг концесс олгогчоос зөвшөөрөл авсны үндсэн дээр хийнэ. Бусад дизайны өөрчлөлтүүдийг хийхдээ Концесс олгогчоос зөвшөөрөл авахгүйгээр бие даасан инженерт мэдэгдсэнээр хийж гүйцэтгэнэ. Материалын дизайн өөрчлөлтийг Хавсралт 1-д тодорхойлно.

4.2.2. Концесс эзэмшигч энэ Гэрээний 3.10-д заасан үйл ажиллагаа эрхлэхгүй байхаас гадна дараах үүрэг хүлээнэ:

- 1) энэ Гэрээний дагуу хийж гүйцэтгэх ажлын тасралтгүй байдлыг хангах;
- 2) концессын зүйлийг энэ гэрээ болон ТЭЗҮ (энэ Гэрээний хавсралт 1)-д заасан нөхцөлд нийцсэн хэмжээнд барьж байгуулан ашиглалтад оруулах ба ашиглах явцын засвар үйлчилгээ, шинэчлэлийг тогтоосон норм, нормативын хэмжээнд хийж, хүчин чадал, техникийн үзүүлэлт, тоног төхөөрөмж, үйлчилгээний чанарыг алдагдуулахгүй ашиглах;
- 3) энэ Гэрээний хэрэгжилттэй холбогдуулж концесс олгогчийн болон зохицуулах байгууллагын хууль тогтоомжийн дагуу шаардсан мэдээ, тайланг тавьсан шаардлага, хугацааны дотор хүргүүлж байх;
- 4) концессын гэрээ дуусгавар болоход энэ Гэрээнд заасан чанарын шаардлагыг хангасан цахилгаан станцын үндсэн болон туслах тоног төхөөрөмж, бусад дагалдах хэрэгслийг техник ашиглалтын бүх баримт бичиг, заавар, зааварчилгаа, ноу-хауг монгол эсвэл англи хэлээр, нууцлалын кодын хамт концесс олгогч эсхүл түүнээс эрх олгосон этгээдэд хүлээлгэн өгөх. Концесс олгогчид шилжүүлсэн бүх баримт бичиг, заавар, зааварчилгаа бусад материалууд нь концесс эзэмшигчийн оюуны өмч байх ба, концесс олгогчид олгосон эдгээр материалын ашиглалтын эрх нь цахилгаан станцын насжилтын хугацаанд зөвхөн тухайн цахилгаан станцын ашиглалтад



- ашиглагдахаар байна.
- 5) барилга байгууламжийн зураг төсөл болон тоног төхөөрөмж бүрийн ашиглалтын зааврыг Монгол хэл дээр орчуулах, концесс олгогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид өгөх (Англи хэл дээр өгөх боломжтой техникийн материалуудаас бусад);
 - 6) төслийн гүйцэтгэгчийн хийсэн барилгын ажлын үе шатны ажлын нарийвчилсан төлөвлөгөө хуваарийг концесс олгогчид ирүүлэх, гүйцэтгэлд нь өдөр тутмын хяналт тавьж, энэ талаар концесс олгогчид хагас жил тутамд нэг удаа тайлагнаж ажиллах;
 - 7) барилга байгууламжийг энэ Гэрээний 3.5-д заасан хугацаанд ашиглалтад оруулах, туршилт хийх ажлыг бүрэн хариуцах, өөрийн болон төслийн гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, санхүүжилт саатсан зэрэг шалтгаанаар төслийг хугацаанд нь оруулаагүйгээс үүсэн гарах хариуцлагыг бүрэн хүлээх;
 - 8) хяналтын гэрээ (энэ Гэрээний хавсралт 10)-ний дагуу концесс олгогчийн томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хамтран ажиллах;
 - 9) цахилгаан станцыг бүрэн хүчин чадлаар нь ашиглах чиглэлээр зохицуулах байгууллагууд болон орон нутгийн эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах;
 - 10) хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээ нэмэгдэх тохиолдолд шалтгаан, үндэслэлийг тухай бүрд нь гаргаж концесс олгогчоор хянуулах ба концесс олгогчоор дамжуулан Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлэх;
 - 11) концессын зүйлийг шилжүүлэх үед концесс эзэмшигч бусдын өмнө хүлээсэн өр, төлбөр, бусдаас авах авлагаа бүрэн барагдуулсан байна;
 - 12) концессын гэрээг хэрэгжүүлэх явцад шаардагдах энэ гэрээнд тусгайлан заагаагүй, ирээдүйд олж авах шаардлагатай тусгай зөвшөөрлийг авах, авсан нийт тусгай зөвшөөрлүүдийг концессын гэрээний хугацаанд, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд концессын зүйлийг шилжүүлэх хүртэл хүчинтэй байлгах. Концесс олгогч нь эдгээр тусгай зөвшөөрлийг авахад нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.
 - 13) эрчим хүчний барилга байгууламжийг барьж байгуулах, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, засвар үйлчилгээ, ашиглалт болон үйлдвэрлэлийн явцад эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, дүрэм журмыг даган мөрдөж ажиллах, тэдгээрт нийцүүлэн өөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг батлан дагаж мөрдөх;
 - 14) нийтийн зориулалттай дэд бүтэц, үйлчилгээг нэмэгдэл орлого олох зорилгоор бусдад ашиглуулсан, түрээсэлсэн тохиолдолд олсон орлогыг орлого, үр дүнгийн тайлан, тэнцэлдээ үнэн зөв тусгаж мэдүүлэх;
 - 15) Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу санхүүгийн бүртгэл тайлан, тооцоог хөтөлж, хуулиар тогтоосон хугацаанд зохих албан татвар төлж байх;
 - 16) барилга байгууламжийг ашиглалтад оруулахдаа эрх бүхий байгууллагаас баталсан "Барилга байгууламж ашиглалтад оруулах дүрэм"-ийг удирдлага болгох бөгөөд түүнд заасны дагуу барилга байгууламжийг тогтоосон хугацаанд Эрх бүхий комисс чанарын сайн үнэлгээтэй хүлээлгэн өгөх;
 - 17) барилга байгууламжийн засвар үйлчилгээг энэ Гэрээний хугацаанд бүрэн хариуцах;
 - 18) концессын гэрээний хугацаанд барилга байгууламжийн засвар

үйлчилгээг нэр хүнд бүхий, туршлагатай гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх, засвар үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг өөрийн хөрөнгөөр болон олж авсан хөрөнгөөр санхүүжүүлэх;

19) Концесс эзэмшигч нь Концесс олгогчийг Төслийн санхүүжилтийн гэрээний талаарх мэдээллээр хангах,

20) концесс эзэмшигчийн буруугаас шалтгаалсан зөрчлийн улмаас барилга байгууламжийг барих явцын болон станцын үйл ажиллагаанд бүхэлд нь энэ Гэрээний 4.1.1.3 дахь заалтын дагуу хөндлөнгийн шинжээч томилох, 4.1.1.8 дахь заалтын дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тохиолдолд тэдгээрийн ажлын хөлс, бусад зардлыг концесс эзэмшигч хариуцна.

ТАВ. КОНЦЕССЫН ГЭРЭЭ ХЭРЭГЖИХТЭЙ ХОЛБООТОЙ БУСАД АСУУДАЛ

5.1. Газар ашиглуулах

5.1.1. Концессын зүйлийг барьж байгуулах газрыг цахилгаан станц барих нутаг дэвсгэрийн орон нутгийн газрын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллага гэрээний үндсэн дээр концесс эзэмшигчид олгоно. Газрыг концесс эзэмшигчид олгох үед аливаа саадаас бүрэн чөлөөлсөн байна. Концессын гэрээнд заасан олгогдох газар нь цахилгаан станц барих газар, холбогдох байгууламжийг барих газар, дагалдах барилгыг барих газар болон цахилгаан станцын барилгын ажлын үед түр ашиглах газрыг тус тус агуулсан байна.

5.1.2. Газрыг концесс эзэмшигчид олгох үед Концессын зүйлийн барилгын ажлыг шууд эхлүүлэхэд бэлэн байна. Концессын гэрээний дагуу цахилгаан станц, холбогдох байгууламж болон дагалдах барилгад зориулсан газар төлөвлөлт гэх мэт газар ашиглахтай холбоотой бүх хууль ёсны үйл ажиллагаа, шаардлага нь Монгол Улсын хуулийн дагуу хийгдсэн эсэхийг Концесс олгогч баталгаажуулна. Түүнчлэн Концесс эзэмшигчид газар олгохоос өмнө Концесс олгогч газар чөлөөлөх, хэрэв тухайн газар дээр холбогдох нийтийн байгууламжууд байгаа тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, татан буулгах, эсвэл дахин байршуулах, зайлуулах ажлыг бүрэн хийгдэж дууссаныг баталгаажуулна. Концесс эзэмшигч нь газар ашигласны төлбөрийг газар ашиглах гэрээ болон бусад газартай холбоотой хуульд заасны дагуу төлнө.

5.1.3. Концесс эзэмшигч олгосон газрыг зөвхөн цахилгаан станц барьж байгуулахад зориулж, газар ашиглах гэрээнд заасан нөхцөлөөр ашиглана.

5.1.4. Газар ашиглах гэрээ (энэ Гэрээний хавсралт 5)-ний хугацаа, нөхцөлийг Газрын тухай хуулийн дагуу тодорхойлно.

5.1.5. Газар ашиглах гэрээ (энэ Гэрээний хавсралт 5)-ний дагуу концесс эзэмшигчийн ашиглах газрыг энэ Гэрээний хүчинтэй байх хугацаанд ямар ч нөхцөлдхурааж авахгүй.

5.1.6. Концесс эзэмшигч нь газар ашиглах гэрээ (энэ Гэрээний хавсралт 5)-ний дагуу газрыг ашиглахдаа Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний дагуу ашиглах үүрэг хүлээх ба газар ашиглалтын үр нөлөөг дээшлүүлэхтэй холбоотой Газрын тухай хууль, Байгаль орчны тухай хуульд заасан шаардлагыг хангаж, ашиглана.

5.1.7. Концесс эзэмшигч нь зөвхөн газар ашигласны төлбөрийг газар ашиглах гэрээ (энэ Гэрээний хавсралт 5) болон Монгол улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Газрын хэвлийн тухай хуульд заасны дагуу төлнө.

5.1.8. Концесс олгогч нь концессын гэрээний хугацаанд газар ашиглах

гэрээний дагуу цахилгаан станц, нэмэлт байгууламжууд болон барилгын явцад түр ашиглах газрыг Концесс эзэмшигч хэвийн ашиглах нөхцөлийг баталгаажуулж, шаардлагатай бүх дэмжлэгийг үзүүлнэ.

5.1.9. Концесс олгогч нь концессын төслийг хэрэгжүүлэх хугацаанд холбогдох бусад газар эзэмших эрх бүхий этгээдүүдээс үзүүлэх зохицуулалтыг хариуцаж, холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд бүх талын дэмжлэг үзүүлнэ.

5.1.10. Хэрэв Концесс олгогч энэ гэрээний 5.1-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүнээс үүдэн Концесс эзэмшигчид учирсан бүх хохирлыг Концесс эзэмшигчид нөхөн олгох, эсвэл Концесс эзэмшигч зөвшөөрсөн тохиолдолд Концесс эзэмшигчид учирсан бүх хохирлыг хаах хэмжээнд барилгын ажлын хугацаа болон Концессын гэрээний хугацааг сунгана.

5.2. Нүүрсний хангалт

5.2.1. Цахилгаан станцын түлшний гол эх үүсвэрийн нөөц нь Багануурын нүүрсний уурхай байна. Багануурын нүүрсний уурхай нэн тэргүүнд Багануурын цахилгаан станцыг нүүрсээр хангах ажлыг Концесс олгогч баталгаажуулна.

5.2.2. Цахилгаан станцад нийлүүлэх нүүрсний хэмжээ, чанар, үнийг тогтвортой байлгах асуудлыг энэ гэрээний ерөнхий зүйлийн 1.3.1-т дурдсан Концесс эзэмшигч, Багануурын нүүрсний уурхайтай байгуулсан "Нүүрс бэлтгэн нийлүүлж, худалдах, худалдан авах гэрээ" (энэ Гэрээний хавсралт 4)-гээр зохицуулна.

5.2.3. Нүүрсний уурхайн хэвийн үйл ажиллагааг хангахад уурхайн удирдлага, орон нутгийн засаг захиргааны байгууллагатай Концесс эзэмшигч бүхий л чиглэлээр харилцан ойлголцож, хамтран ажиллах нөхцөлийг Концесс олгогчийн зүгээс баталгаажуулж, шаардлагатай бүх дэмжлэг тусалцааг үзүүлнэ. Багануурын нүүрсний уурхай Багануурын цахилгаан станцад "цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу шаардлагатай гэрээнд заасан хэмжээний эрчим хүч үйлдвэрлэхэд хангалттай хүрэлцэх хэмжээний нүүрс нийлүүлэхийн тулд нүүрс нийлүүлэх хүчин чадлаа нэмэгдүүлэх тал дээр Концесс олгогч хариуцна.

5.2.4. Хэрэв Багануурын нүүрсний уурхайн нүүрсний чанар, тоо хэмжээ нь цахилгаан станцын шаардлагыг хангахгүй тохиолдолд, Концесс эзэмшигч "цахилгаан худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу шаардлагатай хамгийн бага эрчим хүч үйлдвэрлэхэд цахилгаан станцын хэрэгцээнд хангалттай хэмжээний нүүрсийг ойролцоох бусад нүүрсний уурхайгаас, чанарын хувьд Багануурын нүүрсний уурхайн нүүрснээс муугүй, үнийн хувьд Багануурын нүүрсний уурхайн нүүрснээс илүүгүй үнэтэй авахад Концесс олгогч шаардлагатай бүх дэмжлэг тусалцааг үзүүлнэ. Концесс эзэмшигч нь Концесс олгогчийн тусламжтайгаар цахилгаан станцын ойр орчимд нүүрсний шинээр илэрсэн эх үүсвэрүүдээс нүүрс худалдан авах гэрээ байгуулж нүүрсний нийлүүлэлтийг тогтвортой байлгахад шаардлагатай бүх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

5.2.5. Багануурын цахилгаан станцыг барьж байгуулснаар Концесс олгогч ТЭЗҮ (энэ Гэрээний хавсралт №1)-д дурдсан Багануурын нүүрсний уурхайн үйл ажиллагааг жигдрүүлэх, уурхайг өргөтгөх, хэвийн үйл ажиллагааг хангах, цахилгаан станцыг нүүрсээр тогтвортой хангах тал дээр орон нутгийн эрх бүхий байгууллага, Багануурын нүүрсний уурхайн удирдлагын хамтын ажиллагааг зохион байгуулж шаардлагатай бүх талын дэмжлэг

үзүүлжажиглана.

5.2.6. Багануурын нүүрсний уурхайн нүүрсний нийлүүлэлт багассан, эсвэл бусад нүүрсний уурхайнуудаас орлуулах нүүрс ашигласнаас Концесс эзэмшигчид хохирол учирсан тохиолдолд Концесс олгогч хохирлыг нөхөн төлнө.

5.3. Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах ба үнэ, тариф

5.3.1. Цахилгаан станцыг барьж байгуулж ашиглалтад оруулах явцад Концесс эзэмшигч зохих цахилгаан түгээх сүлжээний компанитай "Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ" байгуулж, барилгын ажилд шаардлагатай эрчим хүч авахад Концесс олгогчийн зүгээс шаардлагатай бүх дэмжлэгийг үзүүлнэ.

5.3.2. Концесс эзэмшигч Цахилгаан станцын үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний борлуулалтыг зохицуулах зорилгоор Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ ТӨҮГ-тай байгуулах гэрээний ерөнхий зүйлийн 1.3.3-д заасан Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ (энэ гэрээний Хавсралт 6)-г байгуулах ажлыг Концесс олгогч баталгаажуулж, шаардлагатай бүх дэмжлэгийг үзүүлнэ. Концесс олгогч Цахилгаан эрчим хүч Худалдах Худалдан авах Гэрээний дагуу цахилгаан станцын үйлдвэрлэх гэрээнд заасан хэмжээний цахилгаан, эрчим хүчийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээнд нийлүүлэхийг баталгаажуулах ба энэ үүргээ биелүүлээгүйгээс Концесс эзэмшигчид учирсан хохирлыг Концесс олгогч нөхөн олгоно.

5.3.3. Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээнд заасан нөхцөлүүдийг мөрдөж ажиллахыг Концесс олгогчоос баталгаажуулна.

5.3.4. Цахилгаан эрчим хүч худалдах үнэ нь Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээнд заасан ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөр илэрхийлэгдэж, төгрөгөөр арилжаалагдана.

5.3.5. Цахилгаан станцын үйлдвэрлэлийн Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээнд заагдсан тогтоосон хэмжээнээс илүү үйлдвэрлэсэн цахилгааныг нэгдсэн сүлжээний дүрэм, диспетчерийн зохицуулалтын дагуу гэрээлэгч тал худалдан авна.

5.3.6. Хэрэв цахилгаан станцын үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээнд заасан хэмжээ, үнээр худалдан аваагүй тохиолдолд Концесс олгогч концесс эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн олгоно.


5.3.7. Хэрэв цахилгаан станцын үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээнд нийлүүлэхдээ тасалсан, эсвэл хэсэгчлэн тасалсан тохиолдолд Концесс олгогчоос концесс эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн олгоно.

5.3.8. Цахилгаан станц ашиглалтад орж, цахилгаан эрчим хүчийг үйлдвэрлэн Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээнд нийлүүлэлт хийж эхэлснээр нийлүүлсэн цахилгаан эрчим хүчийг стандартчилал, хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталгаажуулсан хэмжих хэрэгслийг ашиглан тооцоо хийнэ.

5.3.9. Үйлдвэрлэсэн, нийлүүлсэн цахилгаан эрчим хүчийг хэмжих, тоолох, хяналтын болон хэмжилтийн тоолуур ашиглах, өмчлөхтэй холбоотой харилцааг Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээгээр зохицуулна.

5.4. Даатгал

5.4.1. Концесс эзэмшигч концессын гэрээний хэрэгжилтийн үе шат бүрд



концессын зүйлийг Концессын тухай хуулийн 26.5-д заасны дагуу гэнэтийн ослын даатгалд хамруулсан байна.

5.4.2. Гэрээний 5.4.1-д заасан даатгалын төрөлд даатгуулах үүргээ гүйцэтгээгүйгээс учирсан бүх зардал, эрсдэлийг концесс эзэмшигч өөрийн хөрөнгөөр хариуцна.

5.5. Техникийн нөхцөл, үзүүлэлт

5.5.1. Концессын зүйлийг барьж байгуулах барилгын ажил эхлэхээс өмнө концесс эзэмшигч нь уг барилга байгууламжийг дулаан, уур, цэвэр, бохир ус, холбоожуулалт, цахилгаан, радио, дохиоллын эх үүсвэрт холбох эрх олгосон шийдвэрийг эрх бүхий байгууллагаас гаргуулахад концесс олгогч баталгаа өгнө.

5.5.2. Барилга байгууламжид тавих техникийн улсын хяналтыг холбогдох хуулийн дагуу мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагч хэрэгжүүлнэ. Техникийн улсын хяналт нь цахилгаан станцын болон барилгын ажлын хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй.

5.5.3. Цахилгаан станцыг ашиглалтад оруулах, энэ Гэрээнд заасан нөхцөлөөр хүлээлгэн өгөх үед цахилгаан станцын үндсэн болон туслах тоноглол, дагалдах хэрэгсэл, бусад тоног төхөөрөмжийн байдал, техникийн үзүүлэлт, үйл ажиллагааны бэлэн байдлыг шалган баталгаажуулах, техникийн дүгнэлт, шалгуур нөхцөлийг Монгол улсын хууль болон ТЭЗҮ-нд тусгасны дагуу Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тодорхойлно.

5.5.4. Цахилгаан станцын барилгын ажил болон ашиглалтын үеийн хэвийн үйл ажиллагаанд шаардагдах цахилгаан, дулаан, ус болон бусад нөхцөлүүдийг Концесс эзэмшигчээс үл хамаарах шалтгаанаар нийлүүлээгүй эсвэл эдгээрийг нийлүүлэх үнэ нь харилцан тохиролцооноос өндөр үнэтэй болсон тохиолдолд Концесс эзэмшигчид учрах бүх хохирлыг Концесс олгогч нөхөн олгоно.

5.6. Санхүү, хөрөнгө оруулалт

5.6.1. Концесс эзэмшигч болон түүний холбогдох этгээд нь Концессын тухай Монгол улсын хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх хэсэг, энэ Гэрээний 3.4.1.3)-т заасан шаардлагын дагуу санхүүгийн чадавхтай болохоо нотлох үүрэг хүлээнэ.

5.6.2. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээ энэ Гэрээний Хавсралт 1(ТЭЗҮ)-д заасан хэмжээнд байна. Энэ хэмжээ тогтвортой бөгөөд эцсийн байна. Зөвхөн Засгийн газрын шийдвэрээр өөрчилж болох бөгөөд Концесс эзэмшигчид учирсан бүх хохирлыг Концесс эзэмшигчтэй тохиролцсоны дагуу Концесс олгогч нөхөн олгоно.

5.6.3. Хөрөнгө оруулалтын хэмжээ, хуваарийг "ТЭЗҮ"-нд зааснаар хэрэгжүүлнэ.

5.6.4. Цахилгаан станцын өөрийн өртөг, төслийн санхүүжилт, орлого, үр ашгийн тооцоог ТЭЗҮ (энэ Гэрээний хавсралт 1), барилгын зураг төсөлд заасан төсвийг удирдлага болгож тооцно. Концесс эзэмшигчийн санхүүгийн тайланд тусгагдсан концессын зүйлийн өртгийг тооцохдоо орлого ашгийн дүнг Төв банкнаас зарласан тухайн үеийн валютын ханшаар, жил бүр хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн хуваарийн дагуу тооцон талууд тооцоог нийлж, үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүрийн эхний улиралд багтаан үлдэгдэл өртгийг тодорхойлж, акт үйлдэж байна.



ЗУРГАА. МЭДЭГДЭЛ БА БАТАЛГАА

6.1. Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон талуудын хооронд болон гуравдагч этгээдэддараахи мэдэгдэл, баталгааг гаргаж байна. Үүнд:

6.1.1. Концесс эзэмшигч нь Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, хуулийн этгээдийн болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн бүртгэлд бүртгэгдсэн, хууль, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлдэг болохыг;

6.1.2. Энэ төслийг хэрэгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан компани нь энэ Гэрээний хугацаанд өөр бусад төсөл болон бизнесийн үйл ажиллагаа эрхлэхгүйг;

6.1.3. Холбогдох хууль тогтоомж, үүсгэн байгуулах баримт бичигт заасны дагуу концесс эзэмшигч энэ гэрээг байгуулах, түүнд заасан эрх эдэлж, үүрэг хүлээх болохыг баталгаажуулсан шийдвэрийг Концесс эзэмшигчийн эрх барих дээд удирдлагаас хүлээн авсны үндсэн дээр энэ гэрээ байгуулагдсан болохыг;

6.1.4. Концесс эзэмшигч нь төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө, санхүүгийн найдвартай эх үүсвэртэй, санхүүгийн чадвартай болохыг;

6.1.5. Энэ гэрээгээр хүлээсэн үүрэг нь хууль ёсны, заавал биелэгдэх шинжтэй бөгөөд энэ Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг талууд гэрээнд заасны дагуу бүрэн хүлээхийг;

6.1.6. Талууд энэ гэрээнд хамаарах Монгол Улсын Иргэний хууль болон бусад холбогдох бүх хууль тогтоомжийг биелүүлэх үүрэгтэй болохыг;

6.1.7. Концесс эзэмшигч энэ гэрээг байгуулж буй нь түүний гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ, хэлцэл болон концесс эзэмшигчийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг хөндсөн гэрээ, хэлцэл, санамж бичиг, тушаал, захирамжийг зөрчөөгүй, тэдгээртэй харшлаагүй болохыг;

6.1.8. Төслийн хэрэгжилтэд ноцтой нөлөөлөхүйц эсвэл сөрөг үр дагавар үүсгэх маргаан хуулийн байгууллагад шалгагдаж, хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаагүй, гуравдагч этгээд концесс эзэмшигчийн эсрэг шүүхэд аливаа нэхэмжлэл гаргаагүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаагүй;

6.1.9. Концессын гэрээний хугацаа дуусмагц концесс эзэмшигч нь энэ гэрээний хавсралт 14 дэх Хүлээлгэн өгөх хөтөлбөрийн дагуу төсөл болон концессын зүйлтэй холбоотой Концесс эзэмшигчийн оюуны өмчөөс бусад бүх эрхийг концесс олгогчид бүрэн шилжүүлэхийг;

6.1.10. Концесс эзэмшигчээс концесс олгогч болон төрийн байгууллагад өгөх мэдээлэл нь үнэн зөв бөгөөд мэдээллийг орхигдуулаагүй болохыг;

6.1.11. Концесс олгогч нь Монгол улсын хуулийн хүрээнд концесс олгох болон концессын гэрээ байгуулахбүхий л хууль эрх зүйн чадамж, бүрэн эрхийг хууль ёсны дагуу эзэмшдэг, энэхүү Концессын гэрээнд заасан эрх, үүргийг бүрэн хариуцах чадвартай болохыг.

ДОЛОО. КОНЦЕССЫН ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ГЭРЭЭГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ,ЦУЦЛАХ

7.1. Концессын гэрээ дуусгавар болох

7.1.1. Дор дурдсан үндэслэлээр концессын гэрээ дуусгавар болно:

- 1) талууд харилцан тохирсноор;
- 2) концессын гэрээний үндсэн эсвэл сунгасан хугацаа дууссан;
- 3) концессын гэрээг энэ гэрээний 7.2, 7.3 ба 7.4-д заасан үндэслэлээр цуцалсан.

7.1.2. Концессын гэрээ дуусгавар болсноор концессын зүйлийг эзэмшиж ашиглах концесс эзэмшигчийн эрх дуусгавар болж энэ Гэрээний 7.8-д заасны дагуу концесс эзэмшигч концессын зүйлийг концесс олгогчид хүлээлгэн өгнө.

7.1.3. Энэ Гэрээний 7.2-т заасан үндэслэлээр концессын гэрээг цуцалсан тохиолдолд концесс эзэмшигчийн эрх, үүргийг концесс олгогч өөртөө түр шилжүүлэн авах буюу дараагийн концесс эзэмшигчид энэ Гэрээний 7.8-д заасны дагуу хүлээлгэж өгнө. Хэрэв энэ гэрээний 3.10.4-д заасан нөхцөл биелсэн тохиолдолд Концесс эзэмшигч нь санхүүжүүлэгчтэй хийсэн санхүүгийн гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд, Концесс олгогчийн зөвшөөрснөөр, төслийг санхүүжүүлэгч, төслийг санхүүжүүлэгчийн томилсон гуравдагч этгээдэд шилжүүлэх эрхтэй байна.

7.1.4. Энэ гэрээний 7.9, 8, 9, 10.1, 10.5 болон 10.6 –д заасан концесс эзэмшигчийн эрхүүд нь Концессын гэрээ цуцлагдсаны дараа хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2. Концессын гэрээг Концесс олгогчийн санаачилгаар цуцлах

Хэрэв дараах тохиолдол, эсвэл нөхцөлүүдийн аль нэг нь үүсэн Концесс олгогчоос бичгээр мэдэгдэл авснаас хойш зургаан сарын дотор тухайн нөхцөл байдлыг Концесс эзэмшигч залруулаагүй тохиолдолд концесс олгогч гэрээг цуцлах мэдэгдэл бичгээр өгч 3 (гурван) сарын дараа концессын гэрээг цуцална:

7.2.1. Концесс эзэмшигчийн буруутай үйлдлээс:

1) концесс олгогчийн зөвшөөрөлгүйгээр концесс эзэмшигч энэ Гэрээний 3.10.1 ба 3.10.2-д заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан;

2) концесс эзэмшигч татан буугдсан буюу дампуурсан; (Концесс олгогчийн зөвшөөрөлтэйгээр дотоод дахин зохион байгуулалтад орох зорилгоор Концессын зүйл ба концесс эзэмшигчийн эрх, үүргүүдийг шинээр байгуулагдсан буюу дахин зохион байгуулагдсан этгээдэд шилжүүлснээс бусад);

3) энэ Гэрээнд заасан нөхцөлийн дагуу концесс эзэмшигч Төслийг санхүүжүүлж чадаагүй;

4) Концессын зүйлийг тохиролцсноос бусад зорилгоор ашигласан эсхүл эзэмшсэн ба зөрчил нь Концессын төслийг цаашид хэвийн хэрэгжүүлэх боломжгүй болгосон.

7.2.2. Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах болон нийтийн эрх ашгийн үүднээс Засгийн газрын шийдвэрээр концессын гэрээ цуцлагдаж болно.

7.3. Концесс олгогч үүргээ биелүүлээгүйгээс концесс эзэмшигчийн санаачилгаар концессын гэрээг цуцална:

Хэрэв дараах тохиолдол, эсвэл нөхцөлүүдийн аль нэг нь биелсэн ба үүргээ биелүүлээгүй талаар Концесс эзэмшигчээс бичгээр мэдэгдэл өгснөөс хойш зургаан сарын дотор тухайн нөхцөл байдлыг залруулаагүй тохиолдолд концесс олгогч үүргээ биелүүлээгүйгээс концесс эзэмшигчид учирсан бүх эвдрэл гэмтэл, зардал, хохирлыг нөхөн төлүүлэх эсвэл гурван сарын өмнө бичгээр мэдэгдсэнээр дуусах хугацаанаас нь өмнө концессын гэрээг өөрийн санаачилгаар цуцална:

1) Концесс олгогч холбогдох хууль ба энэ Гэрээнд заагаагүй үндэслэлээр гэрээг цуцлах шийдвэр гаргасан,

2) Эд хөрөнгө нийгэмчлэх, хураах, дайчлан авах,

3) Хуулийн үндэслэлгүйгээр Төсөлтэй холбоотой зөвшөөрлүүдийг олгох, эсвэл шинэчлэхээс татгалзах, хуульд заагаагүй үндэслэлээр

- зөвшөөрлүүдийг цуцлах,
- 4) Үндэсний аюулгүй байдал эсвэл онцгой нөхцөл байдлын улмаас концесс олгогч Концессын гэрээг дуусах хугацаанаас нь өмнө цуцлахаар шийдвэрлэх,
 - 5) Концесс олгогч эсвэл Монгол улсын засгийн газрын эрх бүхий байгууллагаас Төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхүйц хуулийн өөрчлөлт оруулах, хууль гаргах,
 - 6) Концесс олгогч ба холбогдох бусад засгийн газрын эрх бүхий байгууллагууд хуулийн дагуух үүрэг, хариуцлагаа биелүүлээгүй эсвэл Концесс эзэмшигчийн үйл ажиллагаа, барилгын ажилд зүй бусаар саад болох, ингэснээр Концесс эзэмшигчийн Төслийн үйл ажиллагаа, барилгын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон,
 - 7) Концесс эзэмшигчид үл хамаарах шалтгаанаар, Концесс эзэмшигчид газар ашиглах эрх олгохгүй байх, Нүүрс худалдан авах гэрээнд заасан чанар, хэмжээний нүүрсийг авах боломжгүй, эсвэл Цахилгаан эрчим хүч худалдан авах гэрээнд заасан үнэ, хэмжээгээр цахилгаан станцын үйлдвэрлэсэн цахилгааныг борлуулж чадахгүй байх, эсвэл ус ашиглах эсвэл бусад нөхцлүүдийг бүрдүүлэх боломжгүй байх ба аль нэг нөхцөл байдал нь хамгийн багадаа 3 (гурван) сарын хугацаанд үргэлжлэх,
 - 8) Концесс олгогч нь концесс эзэмшигчид хохирлын нөхөн төлбөрийг энэ гэрээнд заасны дагуу барагдуулаагүй.

7.4. Давагдашгүй хүчин зүйл бий болсны улмаас гэрээ цуцлах

7.4.1. Дор дурдсан нөхцөл байдал бийболсоныг давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжгүй болсонд тооцож, аль нэг талын санаачлагаар концессын гэрээг цуцална.

- 1) энэ Гэрээний 10.3-д заасан давагдашгүй хүчин зүйлийн улмаас концессын зүйл устаж алга болсон;
- 2) давагдашгүй хүчин зүйлийн улмаас концессын зүйлд учирсан хохирлыг барагдуулахад концессын зүйлийн орлого хүрэлцэхгүй, түүнийг сэргээн засварлахад шаардлагатай хөрөнгийг талууд гаргах боломжгүй болсон;
- 3) энэ Гэрээний 10.3-д заасан хүчин зүйлийн улмаас энэхүү нөхцөл байдал 3 (гурван) сараас дээш хугацаанд үргэлжлэх нь тодорхой болсон.

7.5 Гэрээг түдгэлзүүлэх

7.5.1. Концессын хугацааг дараах нөхцөлд түдгэлзүүлэх ба түдгэлзүүлэх хугацаа дууссаны дараа Концесс эзэмшигч Гэрээний гүйцэтгэлээ үргэлжлүүлнэ. Концессын хугацаа түдгэлзүүлсэнтэй ижил хугацаагаар сунгагдана.

- 1) Давагдашгүй хүчин зүйл,
- 2) Концесс олгогч концесс эзэмшигчид холбогдох баримт бичиг болон тусгай зөвшөөрлийг олгоогүй.

7.6 Гэрээ цуцлах урьдчилсан мэдэгдэл хүргүүлэх

7.6.1. Гэрээг цуцлах тухай санал, мэдэгдлээ талууд бичгээр хүргүүлнэ.

7.6.2. Гэрээ цуцлах тухай урьдчилсан мэдэгдэл өгснөөс хойш 1 (нэг) сарын хугацаанд талууд нөхцөл байдлыг судалж, гэрээ цуцалснаас үүдэн гарах үйл явдлын үр дагаврыг багасгах зорилгоор зөвлөлдөж, эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах чиглэлээр хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

7.6.3. Концесс эзэмшигчийн үүрэг ноцтой зөрчигдсөнөөс концесс олгогч

түүнд энэ гэрээг цуцлах урьдчилсан мэдэгдэл ирүүлсэн бол концесс эзэмшигч нь энэ тухай хөрөнгө оруулагчнартаа урьдчилан мэдээлнэ.

7.6.4. Мэдэгдэлд заасан хугацаанд концесс эзэмшигч ноцтой зөрчлийг арилгах талаар санаачилга гаргахгүй, шийдвэртэй арга хэмжээ авахгүй, үүссэн нөхцөл байдлыг сайжруулах хүсэлгүй, өөрийн хүчээр ноцтой зөрчил үүсгэж байгаа нөхцөл байдлыг арилгаж чадахааргүй бол концесс олгогч нь энэ талаар хөрөнгө оруулагч нарт бичгээр мэдэгдэж, нэмэлт хугацаа өгөх, шаардлагатай арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулагч нартай шууд харьцаж, өөрийн саналыг хүргүүлж болно.

7.6.5. Талууд гэрээнд өөрөөр тохиролцоогүй бөгөөд давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал өөрчлөгдөөгүй, арилаагүй бол, эсхүл ноцтой зөрчигдсөн үйлдлийг арилгах үүрэг хэрэгжээгүй бол гэрээ цуцлах урьдчилсан мэдэгдэл өгснөөс хойш гурван сарындараа, эсхүл хариу ирүүлэх Монгол улсын Иргэний хуульд заасан хугацаа өнгөрсөн өдрөөс энэ гэрээг цуцлагдсанд тооцно.

7.7. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал тохиролцоонд хүрээгүй тохиолдолд

Энэ гэрээний 3.8.6-д заасан нөхцөл биелсэн тохиолдолд талууд Гэрээний эх хувийг хэвээр мөрдөнө.

7.8. Концессын зүйлийг хүлээлгэн өгөх

7.8.1. Концессын зүйлийг хүлээлгэн өгөх талаар концесс олгогч шийдвэр гаргасан тохиолдолд тухайн шийдвэрийг үндэслэн концесс олгогч концессын зүйлийг хүлээлцэх комиссыг нэн даруй томилно.

7.8.2. Концесс олгогч ба концесс эзэмшигч хамтран концессын зүйлийг хүлээлгэн өгөх эцсийн хугацаа, комиссын бүрэлдэхүүн, комиссын ажлын удирдамжийг батална.

7.8.3. Концессын гэрээний хугацаа дуусгавар болсон тохиолдолд Концессын гэрээний дагуу төлөх үлдэгдэл төлбөргүй бол концессын зүйлийг концесс олгогч эсвэл түүний томилсон этгээдэд үнэ төлбөргүйгээр шилжүүлнэ. Энэ тохиолдолд шилжүүлэх үйл ажиллагаа гэрээний Хавсралт 14-д заасны дагуу хийгдэх ба Гэрээний хугацаа дуусахаас өмнө талуудын хүлээж байсан хариуцлага гүйцэтгэл нь дуустал хэвээр үргэлжилнэ.

7.8.4. Энэ Гэрээний 7.1.1(1), 7.2, 7.3 ба 7.4.-д заасан үндэслэлээр гэрээ цуцлагдаж, дуусгавар болж байгаа тохиолдолд концессын зүйл болон концесс эзэмшигчийн эрх, үүргийг концесс олгогч, түүнээс эрх олгосон этгээдэд шилжүүлж, хүлээлгэн өгөхөд концессын зүйлийг энэ Гэрээний 7.9-д заасан дагуу үнэлж, нөхөн олговор тооцож өгнө. Гэрээ цуцласны нөхөн олговрын төлбөр тооцоо дуусмагц концесс эзэмшигч Концесс олгогч болон концесс эзэмшигчийн хамтран тогтоосон хугацаанд концессын зүйлийг чөлөөлнө.

7.8.5. Төлөгдөөгүй үлдсэн бүх төлбөрийг барагдуулсны дараа, комисс концессын зүйлийг хүлээлцэхдээ дараах зарчмыг баримтална:

1) засгийн газар, концесс олгогч, орон нутгийн өмч, түүнчлэн концесс эзэмшигчийн өмчлөлд үлдэх эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж тодорхойлно;

2) татан буугдсан буюу дампуурсан тохиолдолд концесс эзэмшигчийг дахин санхүүжүүлэх, өөрчлөн байгуулах, эрх үүргийг нь шилжүүлж болох арга хэмжээний төлөвлөгөөг хийж, шийдвэрлүүлэхээр санал болгоно;

3) концессын зүйлийн чанар байдалд мэргэжлийн комисс дүгнэлт

гаргаж, баталгаажуулна;

4) концессын зүйлийг хүлээлцсэн акт үйлдэж, баталгаажуулна.

Концессын зүйлийг хүлээлгэн өгөх үйл ажиллагаа нь энэ Гэрээний хавсралт 14 дэх Хүлээлгэн өгөх хөтөлбөрийн дагуу хийгдэнэ.

7.8.6. Энэ гэрээний 7.1.1 (1), 7.2, 7.3, эсвэл 7.4-д заасны дагуу Концессын гэрээ дуусах хугацаанаасаа өмнө цуцлагдахаас бусад тохиолдолд Концесс эзэмшигч нь энэ Гэрээний хугацаа дуусахаас 1 /нэг/ жилийн өмнөх хугацаанд багтаж концессын зүйлд их засвар хийсэн байна.

7.8.7. Концесс эзэмшигч энэ Гэрээний 7.7.5-д заасан үүргийг биелүүлээгүй тохиолдолд концесс олгогч нь нэг удаа бичгээр үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй бөгөөд шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд концесс эзэмшигч их засварын шаардагдах хөрөнгийг концесс олгогчийн нэрлэсэн дансанд шилжүүлнэ.

7.8.8. Концессын гэрээний дагуу төлөгдөөгүй үлдсэн төлбөр бүрэн хийгдэж дуустал Концесс эзэмшигч концессын зүйлийг хүлээлгэн өгөхөөс татгалзах эрхтэй.

7.9. Концессын гэрээг цуцлах, нөхөн олговрын хэмжээ тооцох

7.9.1. Энэ Гэрээний 7.2.1-д заасан гэрээний үүрэг ноцтой зөрчигдсөний улмаас энэ гэрээ цуцлагдсан тохиолдолд концесс олгогч ба концесс эзэмшигч нар хамтран дор дурдсан томъёоллын дагуу концессын зүйлийн үнэлгээг тооцож, нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлно:

0.9 х (Концесс эзэмшигчийн Төсөлд оруулсан хөрөнгө оруулалт)

7.9.2. Энэ Гэрээний 7.2.2 ба 7.3-д заасан нөхцлийн улмаас энэ Гэрээ цуцлагдсан тохиолдолд концесс олгогч ба концесс эзэмшигч хамтран дор дурдсан томъёоллын дагуу Концессын зүйлийн үнэлгээг тогтоож, нөхөн төлбөрийн хэмжээг тооцож тодорхойлно:

1.1 х (Концесс эзэмшигчийн Төсөлд оруулсан хөрөнгө оруулалт + Тооцоолсон төслийн өгөөж)

7.9.3. Гэрээний 10.3.2 –т заасан давагдашгүй хүчин зүйлүүдийн улмаас 7.4-д заасны дагуу гэрээ цуцлагдах тохиолдолд нөхөн олговрын хэмжээг Концесс олгогч ба концесс эзэмшигч нар хамтран доорх томъёоны дагуу тооцож тодорхойлно:

1.0х(Концесс эзэмшигчийн Төсөлд оруулсан хөрөнгө оруулалт)

7.9.4. Энэ гэрээний 7.1.1 (1)-д заасны дагуу гэрээ цуцлагдсан тохиолдолд концесс олгогч ба концесс эзэмшигч хамтран дор дурдсан томъёоллын дагуу Концессын зүйлийн үнэлгээг тогтоож, нөхөн төлбөрийн хэмжээг тооцож тодорхойлно:

1 х (Концесс эзэмшигчийн Төсөлд оруулсан хөрөнгө оруулалт + Тооцоолсон төслийн өгөөж)

7.9.5. Гэрээ цуцлагдсанаар концесс олгогч концессын зүйлийг нөхөн төлбөргүйгээр концесс эзэмшигч болон эрх олгосон этгээддээ шилжүүлэн авах нөхцөлд үүнтэй холбогдон гарах Концесс олгогчийн аливаа зардал, тэмдэгтийн хураамж, нотариатын төлбөр, холбогдох татвар болон бусад төлбөр, хураамжийг концесс олгогч хариуцна.

7.9.6. Гэрээ цуцлагдсанаар концессын зүйлийг нөхөн төлбөргүйгээр Концесс олгогчболон түүний эрх олгосон этгээдэд шилжүүлэн авах нөхцөлд үүнтэй холбогдон гарах Концесс эзэмшигчийн аливаа зардал, тэмдэгтийн хураамж, нотариатын төлбөр, холбогдох татвар болон бусад төлбөр, хураамжийг концесс эзэмшигч хариуцна.

7.9.7. Гэрээний хугацаа дуусгавар болсноор энэ гэрээний 7.9-д заасны

дагуу Концесс олгогч нөхөн төлбөр болон энэ Гэрээ ба холбогдох гэрээнд заасан бусад бүх үлдэгдэл төлбөрийг концесс эзэмшигчид төлж дууссаны дараа концесс эзэмшигч нь концессын зүйлийг концесс олгогчийн эзэмшил, өмчлөлд аливаа саад учруулахгүйгээр шилжүүлж, хүлээлгэн өгнө.

НАЙМ.ХАРИУЦЛАГА

8.1. Энэ Гэрээний зүйл, заалтыг дор дурдсанаар зөрчсөн нь гэрээг цуцлах үндэслэл болохгүй гэж талууд үзсэн тохиолдолд буруутай талд дараах хариуцлага хүлээлгэнэ:

8.1.1. Гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд, энэ гэрээнд заасан аливаа үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйгээс нөгөө талдаа шууд буюу шууд бус аливаа хохирол учруулсан бол зөрчил гаргасан тал хохирогч талдаа учруулсан бодит хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ. Хохирлын хэмжээг эс зөвшөөрсөн тохиолдолд хохирол нэхэгч тал арбитра хандаж, хохирлын хэмжээг тогтоолгож болно.

8.1.2. Талууд гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд дараах хариуцлага хүлээнэ:

1) Хэрэв хүлээлгэн өгөх ажиллагаа нь Хүлээлгэн өгөх хөтөлбөр (Хавсралт 14)-т тодорхойлсон шаардлагуудыг хангаагүй тохиолдолд Концесс эзэмшигч нь тоног төхөөрөмж, машин техник, цахилгаан хэрэгслүүдийг засварлаж, өөрчилж эсвэл нөхөж өгнө.

2) Цахилгаан станц Концесс эзэмшигчийн буруугаас дөрвөн жилийн дотор ашиглалтанд ороогүй тохиолдолд, Концесс эзэмшигч барилгын ажлын хойшилсон хугацаанд Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний үнийн дүнгийн 10%-тай тэнцэх хэмжээний алданги төлнө. Концесс эзэмшигчийн төлөх алдангийн дээд хэмжээ Концессын Гэрээний үнийн дүнгийн 3%-иас хэтрэхгүй. Харин Концесс олгогчийн буруугаас цахилгаан станц ашиглалтад орох хугацаа хойшлогдсон тохиолдолд барилгын ажлын хугацааг мөн хугацаагаар сунгана.

8.1.3. Хохирлын хэмжээг талууд эс зөвшөөрч байгаа тохиолдолд арбитра хандах эрхтэй.



8.1.4. Концесс эзэмшигч, түүний ажилтан, албан тушаалтан, төлөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч эсвэл төслийн гүйцэтгэгч, гэрээт гүйцэтгэгчийн ажилтнуудын хайхрамжгүй, санаатай болон санамсаргүй, аливаа үйлдэл, эс үйлдлээс шалтгаалж концесс олгогч болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг концесс эзэмшигч хариуцан арилгуулах үүрэгтэй.

8.1.5. Хэрэв Концесс олгогч энэ Гэрээний 4.1.2 дэх үүргээ зөрчсөн тохиолдолд гэрээний үүргээ зөрчсөнөөс үүдэн Концесс эзэмшигчид гарах хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

8.1.6. Концесс олгогч нь Гэрээний 3.3.1 ба 3.3.3-д заасан урьдчилсан нөхцөлийг хангах үүргээ биелүүлэхийн төлөө бүх боломжоороо ажиллах ба биелүүлээгүй тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнд тооцно. Энэ тохиолдолд концесс олгогч нь концесс эзэмшигчид тендерийн баталгааг буцааж, нийт оруулсан хөрөнгө оруулалт болон учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

8.1.7. Энэ гэрээний 3.7.2-д заасан нөхцөл байдлаас болж төслийн барилгын ажил төлөвлөсөн хугацаанд дуусаагүй тохиолдолд концесс эзэмшигч нь гэрээг зөрчсөнд тооцогдохгүй. Энэ тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа гүйцэлдүүлэхгүй ба концесс эзэмшигчийн алдагдлыг буруутай тал нөхөн олгож болно.

8.1.8. Энэ Гэрээний 3.7.2, 3.7.3-т заасан нөхцөл байдал бий болсон



тохиолдолд концесс эзэмшигч нь концесс олгогчоор учирсан алдагдлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх ба талууд өөрөөр тохиролцож чадсан бол зөвхөн концесс эзэмшигчийн зөвшөөрсөн тохиолдолд бусад хэлбэрийн нөхөн олговор хийгдэж болно.

8.1.9. Концесс олгогч нь холбогдох эрх бүхий байгууллагуудтай 1.3-д заасан энэ Гэрээний дагалдах хавсралт гэрээнүүдийг байгуулах ажлыг баталгаажуулна. Энэхүү Төслийн хэвийн үйл ажиллагаа, барилгын хэвийн ажиллагааг хангах үүднээс холбогдох эрх бүхий байгууллагууд эдгээр хавсралт гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхийг Концесс олгогч баталгаажуулна. Хэрэв холбогдох эрх бүхий байгууллага хавсралт гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд Концесс олгогч зөрчлийг арилгах бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба зөрчсөнөөс үүдэн Концесс эзэмшигчид учирсан бүх зардал, эвдрэл гэмтэл, холбогдох хохирлуудыг нөхөн төлөх буюу хэрвээ концесс эзэмшигч зөвшөөрвөл, Барилгын ажлын болон Концессын хугацааг сунгаж болно.

8.1.10. Хэрэв хууль, тогтоомжид орсон нэмэлт өөрчлөлтүүдийн улмаас Концесс эзэмшигчид хохирол учирсан тохиолдолд Концесс олгогч хохирлыг нөхөн төлнө.

ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

9.1. Энэ гэрээнээс үүссэн болон түүнтэй холбогдон гарсан аливаа маргааныг талууд эвийн журмаар, хэлэлцээр хийх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

9.2. Маргааныг харилцан тохиролцох замаар шийдвэрлэж эс чадвал Сингапур улсын Олон улсын Арбитрын "Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрэм"-ийн дагуу шийдвэрлэгдэнэ.

Арбитрын ажиллагааг дараахь зарчмаар явуулна:

9.2.1. Арбитрын шүүхийн арбитрчийн тоо 3 (гурав) байх.

9.2.2. Арбитрчийг Сингапур улсын Олон улсын арбитрын "Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрэм"-д заасан журмын дагуу томилох.

9.2.3. Арбитрын ажиллагааг англи хэл дээр явуулах.

9.2.4. Арбитрын ажиллагааг Сингапур улсын олон улсын Арбитрын "Арбитрын хэрэг шийдвэрлэх дүрэм"-ийн дагуу явуулна.

9.2.5. Арбитрын ажиллагааг Сингапурт явуулна.

9.2.6. Сингапур улсын Олон улсын арбитр үйл ажиллагаандаа энэ гэрээнд заасан хуулийг баримтална.

9.3. Арбитрын шийдвэр нь эцсийнх байх бөгөөд уг шийдвэрийг талууд заавал биелүүлнэ.

АРАВ. БУСАД ЗҮЙЛС

10.1. Хууль хэрэглэх

10.1.1. Гэрээнээс үүдэн гарах аливаа маргааныг шийдвэрлэхдээ Монгол улсын хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны тайлбарыг удирдлага болгоно. Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй аливаа харилцааг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журмын дагуу шийдвэрлэнэ.

10.2. Хууль тогтоомж өөрчлөгдөх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээ

10.2.1. Хэрэв Монгол улсын дотоодын хууль тогтоомж, дүрэм журам, засгийн газрын шийдвэрүүд болон олон улсын гэрээ хэлцлүүдэд гарсан өөрчлөлтүүд нь энэ Гэрээний гүйцэтгэлд эсвэл талуудын эрх ашигт нөлөөлөх тохиолдолд Концесс олгогч концесс эзэмшигчид эдгээр



өөрчлөлтийн талаар бичгээр мэдэгдэнэ.

10.2.2. Концесс олгогч нь өөрчлөлт хийгдсэн бөгөөд Гэрээний хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх аливаа Монгол улсын хууль тогтоомж, Монгол улсын олон улсын гэрээний улмаас Гэрээний хэрэгжих эрх зүйн орчин зайлшгүй өөрчлөгдөх шаардлага гарсан тохиолдолд энэ талаар нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Мэдэгдэлд дараах зүйлсийг тусгана:

- 1) хууль тогтоомжийн эх сурвалж, орсон өөрчлөлтийн агуулга;
- 2) өөрчлөлт нь талуудын ашиг сонирхол, төслийн цаашдын хэрэгжилтэд хэрхэн яаж нөлөөлөх, нөлөөлж эхэлсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- 3) өөрчлөлттэй холбогдон авах арга хэмжээний санал.

10.2.3. Мэдэгдэлийг хүлээн авсан тал хүлээн авснаас хойш 30 (гуч) хоногийн дотор өөрийн саналаа нөгөө талдаа хүргүүлж, хэлэлцэн тохиролцох үүрэгтэй.

10.2.4. Энэ Гэрээний 10.2.3-т заасан хугацаанд хууль тогтоомж өөрчлөгдсөнөөс үүдэн гэрээнд зайлшгүй оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар тохиролцож чадаагүй бол гэрээ цуцлах санал гаргах эрх үүснэ.

10.2.5. Хэрэв энэ Гэрээний 7.3 (5) д заасан нөхцөл байдал үүсэх тохиолдолд Концесс олгогч үүргээ зөрчсөн гэж үзэх бөгөөд Концесс эзэмшигч Гэрээний 7.3-д заасны дагуу гэрээг цуцлах эрхтэй бөгөөд 7.9-д заасны дагуу гэрээ цуцалсны нөхөн төлбөр авна.

10.3. Давагдашгүй хүчин зүйл

10.3.1. Дараах үйл явдал, нөхцөл байдал үүссэнийг давагдашгүй хүчин зүйл бий болсонд тооцож, улстөрийн бусхүчин зүйлд хамааруулан ойлгоно:

- 1) үер, цасан шуурга, газар хөдлөлт, хөрсний гулсалт, дэлбэрэлт, гал түймэр, хүчтэй шуурга, аадар бороо, эрс хүйтрэлт, цаг агаарын гэнэтийн ноцтой үзэгдэл, солирын сүйрэл, геологийн гамшиг зэрэг байгалийн гамшигт нөхцөл байдал бий болох;
- 2) тахал, халдварт өвчин гарах буюу хорио цээр тогтоох;

10.3.2. Дараах үйл явдал, нөхцөл байдал үүссэнийг давагдашгүй хүчин зүйл бий болсонд тооцож, улс төрийн хүчин зүйлд хамааруулан ойлгоно:

- 1) дайн байлдаан, түрэмгийлэл, зэвсэгт мөргөлдөөн болон гаднын халдлага, бүслэлт, худалдааны хориг, хувьсгал, засгийн эрхийн төлөөх хүч түрэмгийлсэн бослого, хуйвалдаан, үймээн, терроризм, улс төрийн зорилго бүхий хорлон сүйтгэх болон барьцаалах ажиллагаа эхэлсэн;
- 2) улс даяар өрнөсөн эсхүл салбар хамарсан ажил хаялт, бослого;
- 3) станцын үйл ажиллагааг эсэргүүцсэн иргэний болон улс төрийн хөдөлгөөн, бослого, улс төрийн жагсаал, цуглаан үймээн.

10.4. Давагдашгүй хүчин зүйл арилсны дараа авах арга хэмжээ

10.4.1. Энэ Гэрээний 10-р зүйлд дурдсан давагдашгүй хүчин зүйлийн энэ Гэрээний 7.4-д зааснаас бусад нөхцөл байдал арилснаар давагдашгүй хүчин зүйл арилсанд тооцож, хохирогч тал нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас хэрэгжүүлэх боломжгүй болсон байсан эрх, үүргээ үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

10.4.2. Давагдашгүй хүчин зүйлийг бий болгож байсан нөхцөл арилсан боловч хохирогч тал нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас хэрэгжүүлэх боломжгүй болсон байсан эрх, үүргээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжгүй бол уг эрх, үүргийг хэрхэн хэрэгжүүлэх талаар Талууд харилцан тохиролцож, шаардлагатай тохиолдолд энэ гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэнэ.

10.4.3. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас энэ гэрээнд заасан эрх, үүргийг хэрхэн хэрэгжүүлэх талаар талууд харилцан тохиролцож, энэ гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд, түүнчлэн энэ Гэрээний 7.4-д заасан нөхцөл байдал үүссэн бол, энэ Гэрээний 7.4-д зааснаар гэрээг цуцлах үндэслэл болно.

10.4.4. Давагдашгүй хүчин зүйл бий болохоос өмнө гүйцэтгэх ёстой байсан мөнгөн төлбөрийн үүргийг давагдашгүй хүчин зүйлийн улмаас гүйцэтгэж чадаагүй нь хохирогч талыг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

10.4.5. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас хохирогч тал гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон нь эрх бүхий байгууллага тогтоосон тохиолдолд учирсан хохирлыг даатгалын нөхөн төлбөрийг ашиглан барагдуулах арга хэмжээ авна.

10.4.6. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас учирсан хохирлыг барагдуулах зорилгоор байгуулсан даатгалын нөхөн төлбөр уг хохирлыг барагдуулахад бүрэн хүрэлцэхгүй тохиолдолд үүнээс үүдэн гарсан хохирлыг талууд адил тэгш хүлээж, хариуцна. Энэ тохиолдолд хохирлын хэмжээг тодорхойлох хөндлөнгийн шинжээчдийн баг ажиллуулна.

10.4.7. Давагдашгүй хүчин зүйл бий болсны улмаас гүйцэтгэх ёстой байсан мөнгөн төлбөрийн үүргийг гүйцэтгэж чадаагүй, энэ Гэрээний 10.4.6-д заасан хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтээр даатгалын нөхөн төлбөр уг хохирлыг барагдуулахад бүрэн хүрэлцэхгүй. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас учирсан хохирлыг барагдуулах зорилгоор байгуулсан даатгалын нөхөн төлбөр уг хохирлыг барагдуулахад бүрэн хүрэлцэхгүй тохиолдолд хохирогч талыг хариуцлагаас чөлөөлөх тухай асуудлыг концесс олгогч шийдвэрлэнэ.

10.4.8. Концесс эзэмшигч давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаанаас урт хугацаагаар энэ гэрээгээр хүлээсэн үүргийг гүйцэтгэхээс татгалзах, эсвэл түдгэлзүүлэх эрхгүй.

10.5. Нууц хадгалах

10.5.1. Талууд энэ Гэрээний дагуу хоорондоо солилцож байгаа, нууцлалын шинжтэй бүх гэрээ хэлэлцээр, баримт бичиг, мэдээллийн нууцлалыг чанд хадгална.

10.5.2. Мэдээллийн нууцад зураг төсөл, барилга байгууламжийн ажил, даатгал, үйл ажиллагаа, засвар, удирдлага, төслийн санхүүжилттэй холбоотой бүх баримт бичиг, тэдгээрт агуулагдсан мэдээлэл хамрагдана. Гэрээний үндсэн дээр олж авсан аль нэг талын үүрэгтэй холбогдсон аливаа баримт бичиг болон мэдээлэл (техникийн эсхүл арилжааны эсэхээс үл хамааран)-ийг гэрээний дагуу үүрэг гүйцэтгэх, эрх хэрэгжүүлэхээс бусад зорилгоор ашиглахгүй. Гэрээний нууц алдагдсанаас аль нэгтэлд хохирол учирвал нууцлалыг задруулсан талаас учирсан хохирлыг Монгол улсын Иргэний хуулийн дагуу нэхэмжлэх эрхтэй.



10.6. Оюуны өмч

10.6.1. Энэ Гэрээний дагуу Концесс эзэмшигчээс концесс олгогчид хүлээлгэн өгсөн мэдээллүүдийг оюуны өмчид хамааруулна. Тухайлбал, оюуны өмч нь ТЭЗҮ, патент, патентийн өргөдөл, зураг төсөл, дизайн, план зураг, инженерийн шугам сүлжээний дэлгэрэнгүй зураг, холболтын схем, технологийн шийдлүүд, худалдааны нууцлал, нээлт, санаа, ноу-хау, процессийн томъёозэрэг нь бичгээр, зургаар эсвэл электрон хэлбэрээр байж болно.

10.6.2. Оюуны өмч Концесс эзэмшигчийн өмч хэвээр байна. Концесс олгогч нь оюуны өмчийг зөвхөн Цахилгаан станцын дотоод хэрэглээнд ашиглах ба бий болгох, худалдах, лицензийн болон давхар лицензийн гэрээ байгуулах, дамжуулах эрхгүй. Концесс олгогч нь оюуны өмчийг дахин үйлдвэрлэх, эсвэл задлах, сайжруулах, өөрчлөх эрхгүй. Концесс олгогч нь оюуны өмчийг дахин боловсруулах, эсвэл задлах, сайжруулах, өөрчлөх болон өөр аргаар урвуу инженерчлэл хийхгүй.

10.6.3 Концесс олгогч энэ гэрээний 10.6 дахь зүйл эсвэл Гэрээгээр хүлээсэн нууцлалтай холбоотой үүрэг хариуцлагаа түүний ажилчид, агентууд, зөвлөхүүд эсвэл хамтрагчид нь зөрчсөн тохиолдолд Концесс эзэмшигчид нөхөшгүй гарз учруулж болзошгүй бөгөөд энэ тохиолдолд Концесс эзэмшигч нь хуулийн дагуу мөнгөн болон бусад хэлбэрээр эрхээ хамгаалуулах эрхтэй.

10.7. Мэдэгдэл хүргүүлэх

10.7.1. Талууд өөрөөр тохиролцоогүй бол энэ Гэрээний дагуу хүргүүлэх шаардлагатай мэдэгдэл, санал, албан бичиг баримтыг биет төлөөлөгчөөрөө дамжуулан биечлэн хүргүүлэх буюу дор дурьдсан хаягаар баталгаат буухиа шуудан, электрон шуудан, факсаар доорх хаягт хүргүүлнэ:

Концесс олгогчид хүргүүлэх:	Концесс эзэмшигчид хүргүүлэх:
Хөрөнгө оруулалтын газар	Багануур Пауэр ХХК
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр, 8-р давхар	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Төмөрчний гудамж 7/1, ЭГЗЭ Плаза 201,
Утас: +976-11-326040, 320706	Утас: +976 88116139
Факс: +976-11-324076	
И-мэйл: nfo@investmongolia.gov.mn	

10.7.2. Талууд хаяг, утас, факсын дугаар болон электрон шуудангийн хаягаа өөрчлөх тохиолдолд өөрчлөхөөс 14 (арван дөрөв) хоногийн өмнө нөгөө талдаа урьдчилан бичгээр мэдэгдэнэ.

10.7.3. Мэдэгдэлийг биечлэн хүргүүлэх бол хүлээн авсныг нотолж хүлээлгэн өгч буй талын баримт бичигт хүлээн авагч талын хүлээн авсан этгээд гарын үсэг зурснаар мэдэгдлийг хүргүүлсэнд тооцно.

10.7.4. Мэдэгдэлийг буухиа шуудангаар хүргүүлэх бол буухиа шуудангийн хүлээлгэн өгсөн баримтад хүлээн авагч тал гарын үсэг зурснаар мэдэгдэлийг хүргүүлсэнд тооцно. Буухиа шуудангийн үйлчилгээ ямар нэг байдлаар саатсан тохиолдолд буухиа, электрон шуудангаар илгээсэн мэдэгдлийг биечлэн эсхүл факсаар дамжуулан хүргүүлнэ.

10.7.5. Мэдэгдэлийг факсаар хүргүүлэх бол факсын төхөөрөмжөөс факсын илгээмжийг амжилттай илгээсэн гэсэн хуудас хэвлэгдснээр мэдэгдэлийг

хүргүүлсэнд тооцно.

10.7.6. Мэдэгдэлийг электрон шуудангаар хүргүүлэх бол хүлээн авагч тал илгээгч талд электрон шууданг хүлээн авсныг хариу электроно шуудангаар мэдэгдсэнээр мэдэгдэлийг хүргүүлсэнд тооцно.

10.7.7. Мэдэгдэлийг хүлээн авсан өдрийг хүлээн авагч талын хүлээн авсан ажлын өдрөөр тодорхойлно.

10.8. Бусад зүйл


10.8.1. Гэрээг байгуулахтай холбогдсон зардлыг талууд тус тусдаа хариуцна.

10.8.2. Энэ Гэрээний ямар нэг нөхцөл, заалт, эрх үүргийг аль нэг тал биелүүлээгүй бол энэ нь гэрээнээс татгалзах үндэслэл болохгүй бөгөөд мөн тэдгээрийг зөрчсөн зөрчилд тохирох арга хэмжээг хэдийд ч авч хэрэгжүүлэх аль нэг талын эрхэд сөргөөр нөлөөлөхгүй.

10.8.3. Гэрээ нь талуудын хооронд ямар нэгэн нөхөрлөл эсхүл хамтарсан компани байгуулах зорилгыг агуулаагүй бөгөөд аль нэг тал нөгөө талынхаа нэрийн өмнөөс гэрээ хэлэлцээр байгуулах, баталгаа гаргах, түүнийг төлөөлөхийг хориглоно.


10.8.4. Гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ гэрээ нь талуудын хоорондын бүх тохиролцоог илэрхийлсэн үндсэн баримт бичиг болох бөгөөд талуудын гэрээг байгуулахаас өмнө энэ Гэрээний зохицуулах зүйлийн талаар хийсэн аман тохиролцоо, мэдэгдэл, хэлэлцээр, ойлголтыг гэрээ бүрэн орлоно.

10.8.5. Гэрээг Англи, Монгол хэл дээр тус бүр 2 /хоёр / хувийг үйлдэнэ. Хувь тус бүр хуулийн адил хүчинтэй байна. Гэрээний англи, монгол хувилбарт ойлголтын зөрчилдөөн гарсан тохиолдолд Англи хувилбарыг баримтална. Талууд хоорондоо англи хэлээр харилцана.



Талууд энэхүү гэрээнд 2015 оны 04-р сарын 01-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурав.

КОНЦЕСС-ӨЛГӨГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА
ЖАВХЛАНБААТАР

КОНЦЕСС
ТӨЛӨӨЛЖ:

ЭЗЭМШИГЧИЙГ

A handwritten signature in black ink, consisting of several stylized characters.

"БАГАНУУР ПАУЭР" ХХК-ИЙН
ТУЗ-ИЙН ДАРГА ВАН ШОУХЭ

- Хавсралт 1
Техник эдийн засгийн үндэслэл.
- Хавсралт 2
Байгаль орчинд нөлөөлөх ерөнхий байдлын үнэлгээ
- Хавсралт 3
Барилгын ажлын үе шатны ажлын төлөвлөгөө
- Хавсралт 4
Нүүрс худалдах, худалдан авах гэрээ
- Хавсралт 5
Газар ашиглах гэрээ
- Хавсралт 6
Цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ
- Хавсралт 7
Дулаан худалдах, худалдан авах гэрээ
- Хавсралт 8
Ус ашиглах гэрээ
- Хавсралт 9
Тусгай зөвшөөрлийн жагсаалт
- Хавсралт 10
Төслийн хяналтын инженерийн зөвлөх компанитай байгуулсан хяналтын гэрээ
- Хавсралт 11
Концесс эзэмшигчийн дүрэм, үүсгэн байгуулах тухай шийдвэр, хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан гэрээ
- Хавсралт 12
Цахилгаан станцын зураг төслийн эх хувь
- Хавсралт 13
Багануурын уурхайн удирдлага болон орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран нүүрсний ордны нөөц хангалтыг сайжруулах нарийвчилсан төлөвлөгөөг баталсан эх хувь
- Хавсралт 14
Хүлээлгэн өгөх хөтөлбөр
- Хавсралт 15
Олон улсын болон үндэсний стандартууд
- Хавсралт 16
Талуудын төлөөллийн итгэмжлэл
- Хавсралт 17
Санхүүжилтийн гэрээний хуулбар

